

**“Ойт хээрийн экосистем болон
ховордож буй амьтдыг нутгийн
иргэдийн оролцоотой хамгаалах нь”
төслийн эцсийн үнэлгээ**

Судалгааны тайлан



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	2
ДҮРС, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	3
ТАЛАРХАЛ.....	5
ӨМНӨТГӨЛ.....	6
ХУРААНГУЙ.....	7
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ.....	11
Судалгааны зорилго	11
Судалгааны хүрээ.....	11
Судалгааны арга зүй.....	13
Судалгаанд ашигласан өгөгдөл, мэдээлэл	15
Судалгааны хязгаарлагдмал тал.....	16
ХОЁР. ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН ТУСГАЙН ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ИРГЭДИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	18
Өрхийн хүн ам зүйн мэдээлэл.....	18
Өрхийн гишүүдийн боловсролын байдал	20
Өрхийн гишүүдийн эрүүл мэндийн байдал	21
Өрхийн амьдралын нөхцөл	21
Өрхийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт	23
ОХЯИ тооцоололт, суурь оны индекстэй харьцуулсан шинжилгээ	23
Нийгэм, эдийн засгийн үр дүнг илэрхийлэх ОХЯИ-ээс бусад үзүүлэлтүүдийн үнэлгээ	25
ГУРАВ. ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	32
Зорилт 1: Ховордож буй амьтан хамгаалал ба мониторинг	32
Зорилт 2: Нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежмент.....	34
Зорилт 3: Бэлчээрийн тогтвортой менежмент бүхий ОНТХГ	38
Зорилт 4: Орлогын олон талт эх үүсвэр бүхий нөхөрлөл, иргэд.....	41
Зорилт 5: ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэх.....	44
ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АСУУДАЛД ТӨСЛӨӨС ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ХАНДАХ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ	48
Ховордож буй зэрлэг амьтны хамгаалал, мониторинг бий болгох талаар иргэдийн хандлага.....	48
Нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох талаар иргэдийн хандлага	49

Бэлчээрийн тогтвортой менежмент бүхий орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг бий болгох талаар иргэдийн хандлага	50
Орлогын олон талт эх үүсвэр бий болгох, малчид, нутгийн иргэд хамтран ажиллах талаар иргэдийн хандлага	51
ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэхтэй холбоотой иргэдийн хандлага	53
ДҮГНЭЛТ	56
ЗӨВЛӨМЖ.....	59
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	60

ТОВЧИЛСОН ҮГС

ОНТХГ	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
ЛАСН	Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОХЯИ	Олон хэмжээст ядуурлын индекс
БЖИ	Биеийн жингийн индекс
БНХМ	Байгалийн нөөцийн хамтын менежмент
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго

ДҮРС, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Төслийн зорилтууд ТХЗ-2030 болон АЙЧИ-20 зорилтуудтай уялдаж буй байдал	12
Дүрс 2. Судалгааны арга зүйн хүрээ.....	14
Дүрс 3. Насны ангиллын хистограмм, n=150.....	18
Дүрс 4. Гэрлэлтийн байдал, хүйсээр, n=150.....	18
Дүрс 5. Боловсролын түвшнээр хистограмм, n=150.....	20
Дүрс 6. Боловсролын түвшин, хүйсээр, n=150.....	20
Дүрс 7. Өрх тус бүрийн сонгогдсон гишүүдийн БЖИ, n=150.....	21
Дүрс 8. Суурь болон төгсгөлийн оны өрхийн сарын орлогын давтамж.....	26
Дүрс 9. Суурь болон төгсгөлийн оны өрхийн сарын дундаж болон медиан орлогын харьцуулалт.....	26
Дүрс 10. Өрхийн аж ахуй эрхлэлтийн байдал, n=150.....	26
Дүрс 11. Өрхийн орлогын хүрэлцээ, n=150.....	27
Дүрс 12. Нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагддаг эсэх, n=150.....	28
Дүрс 13. Дундын хуримтлалын санд сард хуримтлуулдаг мөнгө, төгрөгөөр, n=140.....	28
Дүрс 14. Дундын хуримтлалын бүлэгт хамрагдсанаар үр өгөөж хүртсэн өрхийн эзлэх хувь, n=140.....	28
Дүрс 15. Өөрийн амьдралдаа сэтгэл хангалуун өрхийн эзлэх хувь, n=150.....	29
Дүрс 16. Зэрлэг амьтны тоо толгойн сүүлийн гурван жилийн нөхцөл байдал, n=150.....	32
Дүрс 17. Зэрлэг амьтны тоо толгойн сүүлийн гурван жилийн өсөлт, бууралтын түвшин, n=15.....	32
Дүрс 18. Сүүлийн гурван жилд хулгайн ан буюу хууль бус ан агнуурт гарсан өөрчлөлт, n=150.....	33
Дүрс 19. Ойн нөөцийн нөхцөл байдал, n=150.....	34
Дүрс 20. Ойн нөөцийн доройтол, өсөлтийн түвшин, n=150.....	34
Дүрс 21. Ойн нөхцөл байдлын өөрчлөлт, суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт.....	34
Дүрс 22. Хууль бус мод бэлтгэлийн талаар сонссон эсэх, n=150.....	35
Дүрс 23. Сүүлийн 12 сард хэдэн удаа хууль бус мод бэлтгэлийн хэрэг гарсан, n=150.....	35
Дүрс 24. Хууль бус мод бэлтгэлийн талаар сонсож байсан эсэх, суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт.....	35
Дүрс 25. Сүүлийн гурван жилийн хугацаанд зөвшөөрөлгүй мод бэлтгэлд гарсан өөрчлөлт, n=150.....	36
Дүрс 26. Эргүүлийн идэвхтэн баг байгуулагдсан эсэх, n=150.....	36
Дүрс 27. Бэлчээрийн нөхцөл байдал, n=150.....	38
Дүрс 28. Бэлчээрийн доройтсон байдлын түвшин.....	38
Дүрс 29. Бэлчээрийн нөхцөл байдал, n=150, Суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт.....	38
Дүрс 30. Байгалийн нөөцийг нөхөн сэргээх нөхцөл байдал, n=150.....	39
Дүрс 31. Байгалийн нөөцийг нөхөн сэргээх байдлын бууралт, өсөлтийн түвшин, n=150.....	39
Дүрс 32. Байгалийн нөөц болон бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр явуулсан үйл ажиллагаа, n=150.....	39
Дүрс 33. Сүүлийн гурван жилийн хугацаанд байгалийн нөөц баялгаас орлого олох нөхцөл байдал, n=150.....	41
Дүрс 34. Сүүлийн гурван жилийн хугацаанд байгалийн нөөц баялгаас орлого олох боломжийн түвшин, n=150.....	41
Дүрс 35. Төслийн үйл ажиллагаанд оролцож орлогоо нэмэгдүүлсэн хэлбэр,	41
Дүрс 36. Байгалийн нөөц баялгаас орлого олсон байдал, %.....	41
Дүрс 37. ОНТХГ-ын мэдээлэл, %.....	44
Дүрс 38. Сүүлийн 12 сарын байгаль хамгаалах санаачилгад хамрагдсан эсэх. %.....	44
Дүрс 39. ОНТХГ-т авсан гэдгийг мэдэх эсэх, %, Суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт.....	44

Дүрс 40. Байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд сүүлийн гурван жилийн хугацаанд оролцсон байдал, %	45
Дүрс 41. Ан ав хийхийг хориглох байдал, n=150	48
Дүрс 42. Ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх байдал, n=150.....	48
Дүрс 43. Байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах байдал, n=150	50
Дүрс 44. Хууль бус мод бэлтгэл, байгалийн нөөцийн зөвшөөрөлгүй ашиглалттай иргэн бүр тэмцэх шаардлагатай, n=150	50
Дүрс 45. Байгаль орчныг хайрлан, хамгаалахын ач холбогдол, n=150.....	51
Дүрс 46. Бэлчээр ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулахын ач холбогдол, n=150.....	51
Дүрс 47. Иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилготой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхын ач холбогдол, n=150.....	52
Дүрс 48. Орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулахын ач холбогдол, n=150.....	52
Дүрс 49. Өв соёлыг хайрлан хамгаалахын ач холбогдол, n=150	53
Дүрс 50. Иргэд боловсруулсан бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөл бүрдсэн эсэх, n=150	53
Дүрс 51. Ан амьтдыг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарсан эсэх, n=150	54
Дүрс 52. Тусгай хамгаалалттай газар, бүс бий болгохын ач холбогдол, n=150	54
Дүрс 53. Байгаль хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн эсэх, n=150	55
Дүрс 54. Байгаль хамгаалахад иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай эсэх, n=150	55

Хүснэгт 1. Чанарын анхдагч мэдээлэл цуглуулсан бүлгийн мэдээлэл	15
Хүснэгт 2. Нийт иргэний тоонд эмзэг бүлэгт хамаарах иргэдийн тооны эзлэх хувь	19
Хүснэгт 3. Ядууралд өртсөн өрхийн нөхцөл байдал	23
Хүснэгт 4. ОХЯИ-ийн харьцуулалт	24
Хүснэгт 5. Өрхийн жилийн орлого, төгрөгөөр	25
Хүснэгт 6. Өрхийн орлогын эх үүсвэрийн тоо	26
Хүснэгт 7. Нөхөрлөлийн гишүүд нөхөрлөлөөс хүртэх үр өгөөж, n=142.....	27
Хүснэгт 8. Сүүлийн гурван жилд амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлт	29
Хүснэгт 9. Сард хийсэн эргүүлийн идэвхтэн багийн эргүүлийн тоо,	36
Хүснэгт 10. Байгалийн баялагаас орон нутагт төвлөрсөн орлого, мөнгөн дүнгээр	37
Хүснэгт 11. Нөхөрлөлүүдийн орлогын олон талт байдал, 1-5 оноогоор	42
Хүснэгт 12. Байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон байдал, тоо.....	45
Хүснэгт 13. Оролцогч талуудын ОНТХГ-ын менежментийн тогтолцоог үнэлсэн байдал, 1-5.....	46

ТАЛАРХАЛ

Лондоны амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН)-ийн хэрэгжүүлж буй **“Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь”** төслийн үр дүнгийн үнэлгээний ажлыг Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) 2021 оны 01-р сарын 15-аас 03-р сарын 26-ны хооронд гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд ЛАСН-ээс Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)-т оршин суугаа иргэдийн оролцоотой байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жишиг менежментийг бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн төслийн эцсийн үр дүнг үнэлэхэд чиглэсэн.

Судалгааны ажлыг гүйцэтгэхэд ЛАСН-ийн хамт олны туслалцаа маш их байсан бөгөөд тэр дундаа судалгааны ажлын явцад үнэтэй зөвлөгөө, удирдамж, мэдээллээр хангасан ЛАСН-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын захирал У. Тунгалаг, төслийн мэргэжилтэн Г. Эрдэнэцолмон болон судалгаанд идэвхтэй оролцсон орон нутгийн удирдлага, албан хаагч болон нөхөрлөлийн ахлагч, гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагч та бүхэнд талархал илэрхийлье.

ӨМНӨТГӨЛ

Хараат бус судалгааны хүрээлэн нь ЛАСН-ийн хэрэгжүүлж буй “**Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь**” төслийн үр дүнгийн үнэлгээний ажлыг 2021 оны 01-р сарын 15-аас 03-р сарын 26-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Уг үнэлгээ нь төслийн зорилтот бүс нутаг болох Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн оролцоотой байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар ОНТХГ-ийн жишиг менежментийг бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн төслийн эцсийн үр дүнг үнэлэхэд чиглэсэн.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд **нэгдүгээрт**, Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг үнэлж, төсөл эхэлж байсан 2018 онд хийгдсэн суурь судалгааны¹ үр дүн болон улсын, бүсийн, орон нутгийн бусад иргэдийн амьжиргаатай харьцуулж үзсэн. Тодруулбал, нийгэм, эдийн засгийн үндсэн нөхцөл байдлыг хэмжихэд ашиглагддаг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцох замаар төслөөс үр шим хүртэгчдийн нийгэм, эдийн засгийн байдлыг тодорхойлох; **хоёрдугаарт**, төслийн үйл ажиллагаа бүрийн хэрэгжилт, үр нөлөөг логик хүрээний дагуу үнэлж, дүгнэх; **гуравдугаарт**, иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагыг үнэлэхэд чиглэсэн.

Судалгаанд Архангай аймгийн Булган сумын 881² өрхөөс 150 өрхийг түүвэрлэн зургаан хэсэг, 53 асуулт бүхий асуулгаар анхдагч тоон өгөгдөл цуглууллаа. Түүвэр судалгаанд хамрагдсан 150 өрхийн 134 нь нөхөрлөлийн гишүүн, бусад нь нөхөрлөлийн гишүүн бус өрх байв. Мөн төслийн талаар гол мэдээлэл өгөх иргэд, нөхөрлөлийн гишүүд, орон нутгийн удирдлага, байгаль хамгаалагч зэрэг оролцогч талуудаас хагас бүтэцлэгдсэн ярилцлага авч, анхдагч, чанарын мэдээллийг цуглууллаа. Дээрх бүлгүүдийг хамруулж, нийт 18 ярилцлага хийсэн байна.

Судалгааны тайлан нь (i) судалгааны аргазүй, (ii) Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлын үнэлгээ, (iii) төслийн үр нөлөө, хэрэгжилтийн үнэлгээ (iv) иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагын үнэлгээ (v) дүгнэлт гэсэн таван үндсэн бүлгээс бүрдэнэ.

¹ (Хараат бус судалгааны хүрээлэн, 2018.9-2019.2)

² (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2020)

ХУРААНГУЙ

Энэхүү тайланд нийгэм-эдийн засгийн судалгаа, чиг хандлагууд, ялангуяа ОНТХГ-ын ховордож буй амьтдын нөхцөл байдал, ойн менежмент, бэлчээрийн тогтвортой менежмент, нутгийн иргэдийн орлогын олон талт байдал, ОНТХГ-ын үр дүнтэй, менежмент хамгааллын тогтолцоотой холбоотой судалгаа шинжилгээний үр дүнгүүдийг багтаасан. Тайлангаас орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин, боловсрол, эрүүл мэнд зэрэг орон нутгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын талаарх нарийвчилсан үнэлгээний үр дүн, мөн орон нутгийн байгалийн нөөцийн өнөөгийн нөхцөл байдал, нөхөрлөлүүдийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцооны түвшний үнэлгээ болон иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагын үнэлгээ зэргийг хүлээн авах боломжтой.

Судалгааны үр дүнг баталгаажуулж, давхар шалгах болон талуудын байр суурийг илэрхийлэх, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх зорилгоор судалгааг тоон болон чанарын аргуудыг ашиглан хийж гүйцэтгэсэн. Тоон судалгааны аргын хувьд төслийн суурь судалгааны үр дүнтэй харьцуулах боломжтой байх үүднээс орон нутгийн иргэдийн амьжиргааг үнэлэхдээ ОХЯИ-г өргөн хүрээнд ашигласан.

Судалгааны гол үр дүнг тоймлон харуулбал:

- Судалгаанд оролцогчдын насны бүтцийн хувьд хамгийн залуудаа 22 настай, хамгийн ахмад нь 66 настай, дунджаар 41 иргэн буюу нийт иргэдийн 74%, дөрвөн иргэний тутмын гурав нь 30-49 насны иргэн байна. Түүнчлэн, 150 иргэний 50% буюу 75 нь эмэгтэй, үлдсэн 75 нь эрэгтэйчүүд байна. Өрхийн ам бүлийн хувьд ганц бие амьдардаг нэг өрх байсан бол хамгийн өнөр айл 8 ам бүлтэй байна. Дунджаар 4-5 ам бүлтэй, 2-3 хүүхэдтэй, өрхийн тэргүүн эсвэл гол орлого ологч нь энэ нутагтаа ойролцоогоор 30 жил амьдарч байгаа өрхүүд байна. Судалгаанд хамрагдсан өрхийн нийт гишүүдийн 95.8% нь халх, үлдсэн 4.2% өөлд, хотон, дархадууд байна.
- Төгсгөлийн шатны судалгааг суурь шатны судалгаатай харьцуулан шинжилсэн ба ОХЯИ суурь шатанд 0.115 байсан бол эцсийн шатанд 0.084 болж, 0.031 функтээр буурчээ. Тодруулбал, олон хэмжээсээр тооцсон ядуу хүмүүсийн нийт хүний тоонд эзлэх хувь суурь шатнаас эцсийн шатанд 0.297-оос 0.229 болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, суурь шатанд судалгаанд оролцсон нийт хүний 29.7 хувь нь ядуу байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 22.9 хувь болж буурчээ. Олон хэмжээст ядуурлын эрчимжилт суурь шатнаас эцсийн шатанд 0.389-өөс 0.365 болж, 0.024 функтээр мөн буурсан буюу суурь шатанд ядууралд өртсөн өрхүүдийн 38.9 хувь нь нийт үзүүлэлтийн хувьд гачигдалтай байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 36.5 хувь буурсан гэсэн үг. Ийнхүү дэд хоёр индекс хоёул тодорхой хэмжээгээр буурсан нь ОХЯИ эцсийн дүнд буурахад нөлөөлөв.
- ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлын өөрчлөлтийг авч үзвэл ОХЯИ суурь онд 0.115 байсан бол эцсийн үнэлгээгээр 0.084 болж, буурсан байна. Тодруулбал, ядуурлын индекс буурна гэдэг нь суурь онтой харьцуулахад тухайн орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал сайжирсныг илтгэнэ. Нөхөрлөлийн гишүүн өрхийн амьжиргаа дээшилсэн болон төсөлд хамрагдаагүй нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад өндөр байгаа тул уг төсөл өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна гэж дүгнэх боломжийг үүсгэж байна.
- Төсөл хэрэгжсэнээр ОНТХГ-ын ховордож буй амьтдын тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд өссөн хэмээн үзэж байна. Ялангуяа буга, тарваганы тоо толгой мэдэгдэхүйц өссөн байна. Энэхүү байгалийн ховордож буй амьтдын тоо толгой өсөж байгаа нь нөхөрлөлүүдийн хяналт

сайжирсан, камержуулсан, хууль бус мод бэлтгэлийн зам давааг хаасан, хулгайн ан багассан болон хууль дүрэм сайжирсантай холбон тайлбарлаж байна. Мөн төслийн хүрээнд зохион байгуулсан байгаль орчны мэдлэг олгох сургалт, нөлөөллийн ажилтай холбон тайлбарлаж байна.

- Төсөл хэрэгжихээс өмнө ой бүхэлдээ хямралд өртсөн байсан хэмээн судалгаанд оролцогчид тодорхойлсон. Энэ нь ОНТХГ-аас нутгийн иргэд зөвшөөрөлгүй түлшний мод бэлтгэж байсантай холбоотой. Харин төсөл хэрэгжсэний дараа нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулж эхэлснээр зөвшөөрөлгүй замуудыг хаах, камержуулах, идэвхтэн байгаль хамгаалагчид хяналт хийж эхэлснээр нөхцөл байдал ихээхэн сайжирсан байна. Мөн нөхөрлөлд ойн цэвэрлэгээний зөвшөөрөл бүхий талбайг зааж өгснөөр нутгийн иргэдийн мод бэлтгэлийг хянахын зэрэгцээ иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна. Мөн хулгайн мод бэлтгэл багассан байна.
- Төсөл хэрэгжсэнээс үл хамааран бэлчээрийн нөхцөл байдал сүүлийн гурван жилийн хугацаанд муудсан хэвээр байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн. Бэлчээрийн нөхцөл муудаж байгаа шалтгааныг малчид тайлбарлахдаа голлон малын тооны өсөлт, байгаль цаг уурын өөрчлөлт, өнгөрсөн хоёр жилийн хавар, зуны гантай холбон тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл байгаль цаг уурын өөрчлөлтийг төслийн болон малчдын зүгээс удирдан чиглүүлэх боломжгүй юм. Орон нутгийн иргэдийн хувьд бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор бэлчээр сэлгэн нүүдэллэх, хадлангийн талбай хашаалах, өвөлжөө газраа намар, хавартаа нутаглах байх зэрэг алхмуудыг хэрэгжүүлж байна. Мөн иргэдийн хувьд бэлчээрийн нөхцөл байдлыг дээшлүүлэхийн тулд малын чанарыг сайжруулах, малын тоог багасгах, өөр сумаас ирж нутаглаж байгаа отрын малчдыг багасгах болон онцгойлон аймгийн төвийн харьяалалтай малчдыг цөөлөх тал дээр анхаарах, хамтарч ажиллах хэрэгцээг тэмдэглэж байсан. Үүнээс үзвэл нутгийн иргэдийн хувьд бэлчээрийн нөхцөл байдал тулгамдсан асуудал болсон гэдгийг ойлгосон ба шийдвэрлэх арга зам дээр санал нэгдэж байгааг харж болохоор байна.
- Нутгийн иргэдийн үзэж буйгаар нөхөрлөлд хамрагдсан өрхүүдийн орлогын төрөлжилт нэмэгдсэн байна. Орлого нэмэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь ойн цэвэрлэгээний болон дундын сангийн хуримтлалын орлоготой холбоотой байна. Өрхийн орлогын төрөлжилтийг нэмэгдүүлэх зорилгоор ойн цэвэрлэгээ хийх тоног төхөөрөмж болон нөхөрлөлийн дундын санг бий болгох, жижиг бизнес эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн нь үр дүнтэй болсон байна. Нөхөрлөлийн ахлагчдын хувьд төслөөс өгсөн тоног төхөөрөмжөөр цагаан идээ боловсруулах, газар тариалан эрхлэх гэх мэт үйл ажиллагаануудыг явуулах болсон ба дундын санд хуримтлал бий болгосноор өрхийн амьжиргаанд ч нөлөөлж байна. Нөхөрлөлийн гишүүдийн хувьд ойн цэвэрлэгээ болон цагаан идээ үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн тусламжтайгаар орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлж байна. Төрийн албан хаагчдын хувьд цагаан идээ, модны чиглэл, блок цохих болон ойн цэвэрлэгээ хийх гэх мэтээр бүх нөхөрлөлүүд тодорхой хэмжээний орлогын олон талт эх үүсвэртэй болсон гэж үзсэн байна.
- Оролцогч талуудын үзэж буйгаар ОНТХГ-ын хамтын нөхөрлөлийн менежментийн бий болгох үйл ажиллагаа “маш сайн” үр дүнтэй байгааг онцолж байна. ОНТХГ-т хамтын нөхөрлөлийн менежментийг бий болгосноор өмнөхөөсөө илүү эерэг өөрчлөлтүүд гарч, төслийн баг болон орон нутгийн иргэд сайн хамтын ажиллагааг бий болгож чадсан хэмээн үзэж байна. Харин орон нутгийн удирдлага, албан хаагчтай төдийлөн сайн хамтарч ажиллаж чадаагүй хэмээн талууд дүгнэж байна.
- Иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагыг тодорхойлсон. Үр шим хүртэгчдийн дийлэнх олонх нь ан авч хийхийг ямар нэг

байдлаар зохицуулах, дэлхийн ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх ажлыг дэмжих хэрэгтэй хэмээн үзсэн.

- Байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах нь ач холбогдолтой гэж нийт өрхийн 81. гурван %, хууль бусаар мод бэлтгэж, нөөц ашиглаж байгаа байдлыг таслан зогсооход иргэн бүрийн оролцоо чухал гэдэгтэй нийт өрхийн 95.3% нь санал нийлж байна. Иймд нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгохын ач холбогдол, үр өгөөжийг иргэд нийтээр ойлгож, дэмжих хандлагатай байна.
- Бэлчээрийн тогтвортой менежмент бүхий ОНТХГ-г бий болгоход 90.6% нь байгаль орчноо хамгаалах нь ач холбогдол өндөр гэж үнэлсэн бол ач холбогдолгүй хэмээн үнэлсэн өрх байхгүй байна. Бэлчээр ашиглалтыг нөхөрлөл, холбооны үйл ажиллагаа, дүрэм, журмаар зохицуулах нь ач холбогдолтой гэж нийт судалгаанд оролцогчдын 78.7% нь үнэлжээ. Иргэдийн дийлэнх олонх нь бэлчээрийн тогтвортой менежмент бүхий орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг бий болгохын ач холбогдлыг өндрөөр үнэлдэг болсон нь харагдаж байна.
- Байгалийн нөөц, баялгаа зохистой ашиглан, уламжлал өв соёлоо хайрлан хамгаалж, малчид, нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь ач холбогдолтой гэж ойролцоогоор дөрвөн хүн тутмын гурав нь үнэлжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх олонх буюу 87.4% иргэд одоогоор байгалийн болон соёлын нөөцөө зүй зохистой ашиглаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн, зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөл бүрдсэн гэдэгтэй санал нийлж буй байдал нь малчид, нөхөрлөлийн гишүүд орлогын олон талт эх үүсвэртэй болсныг харуулж байна. Түүнчлэн орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулах нь ач холбогдолтой гэж нийт оролцогчдын 75.3% үнэлсэн төдийгүй нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад гишүүн өрх энэ ач холбогдлыг илүү өндөр үнэлэх магадлалтай байгаа нь уг төслийн чухал үр дүн юм.
- ОНТХГ-ын сүлжээгээр дамжуулж, ойт хээрийн экосистемийг хамгаалахад иргэд (ойн нөхөрлөл, бэлчээр ашиглалтын хэсгүүд), орон нутгийн засаг захиргааны байгууллага (байгаль орчны газар, ойн анги, газрын алба, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллага)-ууд хамтран ажиллах шаардлагатай гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 98% нь үзсэн. Оролцогч талуудын хувьд ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь өндөр ач холбогдолтой гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэд бүрэн (100%) санал нэгдэж байна.



**НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ,
АРГАЧЛАЛ**

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго

ЛАСН-ээс Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол–Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн оролцоотой байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жишиг менежментийг бий болгох зорилгоор 2018 оны 7 сараас 2021 оны гурван сар хүртэл хугацаанд хэрэгжүүлсэн төслийн эцсийн үр дүнг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны баг зорилгодоо хүрэхийн тулд төсөл хэрэгжсэнээр (1) Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал болон (2) Хойд Могойн гол орчмын биологийн олон янз байдалд гарсан үр нөлөөг шинжилж, (3) байгаль хамгаалал, тогтвортой хөгжил, байгалийн нөөцийг зохистой, тэгш, хүртээмжтэй ашиглах талаар орон нутгийн иргэд ямар үзэл бодол, хандлагатай болсныг тодорхойсон болно. Эдгээр шинжилгээг хийхдээ төслийн эхэн үе болон төгсгөл үеүдэд төслөөс үр шим хүртэгчдийн нөхцөл байдлыг харьцуулан судлахаас гадна тухайн аймаг, орон нутгийн бусад иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал, байгаль орчины нөхцөл байдалтай зэрэгцүүлэн үнэлж, дүгнэх болно. Түүнчлэн судалгаанд төсөл хэрэгжсэн орон нутгийн зорилтот/эмзэг бүлгийн иргэдийг хамруулж, жендерийн асуудлыг хөндсөн болно.

Судалгааны хүрээ

ЛАСН-ээс хэрэгжүүлсэн уг төслийн зорилго, үйл ажиллагаа НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) - 2030” болон биологийн олон янз байдлын конвенц болох “АЙЧИ 20” зорилтуудтай хэрхэн уялдаж байгааг Дүрс 1-д харууллаа.

Нутгийн иргэдэд түшиглэсэн ойн болон бэлчээрийн тогтвортой менежмент бүхий ОНТХГ-ыг байгуулж, зэрлэг, ховордож буй амьтны хамгаалал, мониторинг хийж, орлогын олон талт эх үүсвэр бүхий иргэд, нөхөрлөлийг дэмжих замаар ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэхэд төслийн үндсэн үйл ажиллагаа чиглэгдэж байв. Эдгээр үйл ажиллагаа нь “АЙЧИ 20”-ын 1, 2, 5, 7, 11, 12, 14, 17, 18 дугаар зорилтууд Дүрс 1-ийн ногоон дэвсгэртэй хүрээнд харуулав)-тай нягт уялдаж, Архангай аймгийн Булган сумын хуурай газрын эко системийг хамгаалж, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, жендерийн эрх, тэгш байдлыг хангаж, иргэдийн амьжиргааг дэмжин, баталгаат ажлын байрыг бий болгох замаар ядуурал, өлсгөлөнг зогсоох, эдийн засгийн өсөлтийг бий болгох хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, “ТХЗ 2030”-ын 1, 2, 5, 8, 13, 15, 17 дугаар зорилтууд Дүрс 1-ийн цэнхэр дэвсгэртэй хүрээнд харуулав)-ыг хангахад хувь нэмэр оруулсан байна.

Уг судалгаа нь Тээлийн ОНТХГ-ын байгаль орчин, нутгийн иргэдийг хамруулан дээрх зорилтуудын уялдааг харгалзан төслийн логик хүрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үр дүнг үнэлсэн.

Дүрс 1. Төслийн зорилтууд ТХЗ-2030 болон АЙЧИ-20 зорилтуудтай уялдаж буй байдал



Мэдээллийн эх сурвалж: (Monica Wrobel, Tungalag Ulambayar, Samuel Merson, Erdenetsolmon Ganbaatar, Khaliun Tsog, 2020)

(United Nations, Sustainable Development Goals, 2015-2030)

(Aichi Biodiversity Targets, 2020)

Судалгааны арга зүй

Судалгааны арга зүйн ерөнхий хүрээг Дүрс 2-т үзүүлээ. Судалгааны баг зорилгодоо хүрэхийн тулд үндсэн гурван зорилтыг дэвшүүлээ.

Судалгааны хамгийн эхний зорилт бол Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг үнэлж, төсөл эхэлж байсан 2018 онд хийгдсэн суурь судалгааны³ үр дүн болон улсын, бүсийн, орон нутгийн бусад иргэдийн амьжиргаатай харьцуулах явдал юм. Энэ зорилт жендэрийн эрх, тэгш байдлыг хангаж, баталгаат ажлын байрыг бий болгох замаар ядуурлыг бууруулж, өлсгөлөнг зогсоох, эдийн засгийн өсөлтийг бий болгох тогтвортой хөгжлийн зорилгуудтай илүү уялдаатай байв. Суурь болон эцсийн үр дүнг хооронд нь харьцуулахын тулд суурь судалгаанд ашигласан арга зүйг өөрчлөхгүйгээр эцсийн үнэлгээнд ашиглав. Тодруулбал, нийгэм, эдийн засгийн үндсэн нөхцөл байдлыг хэмжихэд ашиглагддаг ОХЯИ тооцох замаар төслөөс үр шим хүртэгчдийн нийгэм, эдийн засгийн байдлыг тоон үзүүлэлтээр харьцуулав.

ОХЯИ нь гол хоёр мэдээллийг хослуулан ядуурлын гүнзгийрлийг хэмждэг: (1) ядууралд хамрагдах тохиолдол буюу (өгөгдсөн хүн амын) олон хэмжээст ядууралд өртсөн хүн амын харьцаа, мөн (2) тэдний гачигдал хомсдолын эрчимжилт буюу гачигдал хомсдолын жинлэгдсэн дундаж харьцаа зэрэг юм. Энэ индексийг тооцох аргачлалыг уг тайлангийн “Өрхийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт” хэсэгт дэлгэрэнгүй үзүүлэв.

Суурь судалгаанаас ялгаатай нь эцсийн үр дүнг үнэлэхдээ ОХЯИ-д нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох регрессийн шинжилгээ хийв. Ингэснээр өрхийн тэргүүний боловсрол, нас, нөхөрлөлийн гишүүн эсэх зэрэг өрхийн онцлогоос хамаарч тухайн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал ялгаатай эсэхийг тодорхойлох боломж бүрдсэн юм. Түүнчлэн, энэ хэсэгт баримт, бичгийн судалгаа хийж, төслөөс үр шим хүртэгчийн нөхцөл байдлыг тухайн орон нутгийн бусад иргэдтэй харьцуулан дүгнэлээ.

³ (Хараат бус судалгааны хүрээлэн, 2018.9-2019.2)

Дүрс 2. Судалгааны арга зүйн хүрээ

Судалгааны зорилго: ЛАШН-ээс Архангай аймгийн Булган сумын Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн оролцоотой байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жишиг менежментийг бий болгох зорилготой хэрэгжүүлсэнтөслийн эцсийн үр дүнг үнэлэхэд уг судалгааны зорилго оршино.



Судалгааны хоёр дахь гол зорилт төслийн үйл ажиллагаа бүрийн хэрэгжилт, үр нөлөөг логик хүрээний дагуу үнэлж, дүгнэх явдал байв. Энэ зорилтыг хангахын тулд судалгааны баг төслийн баримт бичгүүд, холбогдох материалуудыг судалж, нийт таван зорилт, 21 шалгуур бүхий логик хүрээний дагуу төслийн үйл ажиллагаа бүрийн үр дүнг тоон болон чанарын судалгааны арга зүй ашиглан үнэлсэн юм. Уг үнэлгээгээ суурь онтой харьцуулан дүгнэсэн болно.

Гурав дахь гол зорилт бол иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагыг үнэлэх явдал байв. Уг зорилтдоо хүрэхийн тулд судалгааны баг 150 өрхөөс авсан асуулгын өгөгдлийг ашиглан энгийн статистик шинжилгээ, харьцуулсан шинжилгээ, вариацийн шинжилгээ хийлээ.

Судалгаанд ашигласан өгөгдөл, мэдээлэл

Судалгааны баг анхдагч болон хоёрдагч тоон болон чанарын өгөгдөл, мэдээллийг ашиглан судалгаагаа хийлээ. Судалгааны зорилгыг хангахын тулд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд ашигласан өгөгдөл, мэдээллийн төрлийг Дүрс 2-д харуулав.

Анхдагч тоон өгөгдөл

Архангай аймгийн Булган сумын 881⁴ өрхөөс 150 өрхийг түүвэрлэн зургаан хэсэг, 53 асуулт бүхий асуулгаар анхдагч тоон өгөгдөл цуглууллаа. Түүвэр судалгаанд хамрагдсан 150 өрхийн 134 нь нөхөрлөлийн гишүүн, бусад нь нөхөрлөлийн гишүүн бус өрх байв.

Анхдагч, чанарын мэдээлэл

Төслийн талаар гол мэдээлэл өгөх иргэд, нөхөрлөлийн гишүүд, орон нутгийн удирдлага, байгаль хамгаалагч зэрэг оролцогч талуудаас хагас бүтэцлэгдсэн ярилцлага авч, анхдагч, чанарын мэдээллийг цуглууллаа. Дараах бүлгүүдийг хамруулж, нийт 18 ярилцлага хийсэн байна.

Хүснэгт 1. Чанарын анхдагч мэдээлэл цуглуулсан бүлгийн мэдээлэл

№	Бүлэг	Ярилцсан хүний тоо
1	Нөхөрлөлийн холбооны гүйцэтгэх захирал	1
2	Нөхөрлөлийн ахлагч	6
3	Өрх толгойлсон эрэгтэй	1
4	Төрийн албан хаагч	5
5	Идэвхтэн байгаль хамгаалагч ба байгаль хамгаалагч	5

Анхдагч мэдээллийг цуглуулахдаа жендэрийн тэгш байдлыг хангаж, зорилтот бүлгүүдээс мэдээлэл цуглуулахыг хичээн ажилласан юм. Энд, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн төлөөлөл нэг өрхөөс ярилцлага авсан. Харин өрх толгойлсон эмэгтэйчүүд судалгааны явцад илрээгүй тул энэ бүлгийн мэдээлэл цуглараагүй.

Хүснэгт 1-д үзүүлсэн бүлгийн төрийн албан хаагч ангилалд сумын засаг дарга, сумын засаг даргын орлогч, багийн засаг дарга, байгаль орчны улсын байцаагч, экологийн цагдаа гэсэн төлөөллүүдтэй ярилцлаа.

Тоон болон чанарын хоёрдогч мэдээлэл

Судалгааны баг тоон болон чанарын анхдагч өгөгдөл, мэдээлэлд шинжилгээ хийхээс гадна дараах хоёрдогч өгөгдөл, мэдээллүүдийг ашиглаж, төслийн эцсийн үр дүнг үнэллээ. Үүнд:


- Төслийн үйл ажиллагааны жилийн болон хагас жилийн тайлангууд
- Хойд Могойн гол – Тээлийн ОНТХГ менежментийн төлөвлөгөө, 2018-2023
- ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм-эдийн засгийн суурь судалгаа, 2018 он
- Төслийн үр дүнг хэмжих үнэлгээ, мониторингийн логик хүрээ
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн статистик мэдээ, холбогдох тайлан

⁴ (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2020)

Судалгааны хязгаарлагдмал тал

2020 оны 1 сард дэлхий дахинд COVID-19 цар тахал дэгдэж, Монгол Улс дотооддоо хэсэгчилсэн болон бүтэн хөл хорио тогтоосон. Энэ хугацаанд нийгэм, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа зогсонги байдалд орж, төслийн төлөвлөгөөт ажил хэрэгжихэд бэрхшээл учирсан байна. Түүнчлэн, төслийн эцсийн үр дүнг хэмжих энэхүү судалгааны ажил COVID-19 халдвараас сэргийлж, хатуу хөл хорио тогтоосон үед явагдсанаараа онцлог байлаа. Судалгааны багийн гишүүд Архангай аймагт талбарт ажиллах боломж хязгаарагдмал байсан тул тоон болон чанарын мэдээллийг утсаар цуглуулсан. Мөн төслийг хэрэгжүүлэгч багийн гишүүд судалгааны багийн гишүүд онлайнаар хуралдаж, цахим орчинд хамтран ажилласан.

Уг нөхцөл байдлаас үүдэн судалгааны баг төсөл хэрэгжсэн газар дээр очиж, төслийн үр шим хүртэгчидтэй уулзаж, тэдний нөхцөл байдалтай бодитоор танилцах боломж хязгаарлагдмал байв. Мөн мэдээлэл цуглуулах явцад зарим талаараа хүндрэл учирч, судалгааны баг үнэн, бодит мэдээлэл цуглуулахын тулд илүү их хүчин чармайлт гарах шаардлагатай тулгарч байлаа.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТЭЭЛИЙН ОРОН
НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАРТ
ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

ХОЁР. ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН ТУСГАЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ИРГЭДИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

2018 оны хоёрдугаар хагасаас хойш ЛАСН-ээс хэрэгжүүлсэн төслийн үр дүнд Архангай аймгийн Булган сумын Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдалд хэрхэн өөрчлөлт гарсныг судалж, нэгтгэн бичлээ.

Энэ хэсгийн үнэлгээг хийхдээ баримт бичгийн судалгаа хийж, 150 өрхөөс авсан түүвэр судалгааны мэдээлэлд үндэслэн ОХЯИ-ийг байгуулан, төслийн гол оролцогч талуудын төлөөллөөс хагас бүтэцлэгдсэн ярилцлагаар цуглуулсан чанарын мэдээллийг шинжилж, суурь болон эцсийн үр дүнг харьцуулан дүгнэсэн юм.


Өрхийн хүн ам зүйн мэдээлэл

Түүвэрт хамрагдсан өрхийн хүн ам зүйн мэдээлэл нь төсөл нийгмийн ямар бүлэг рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулж, ямар үр дүнд хүрсэн бэ гэдгийг ойлгоход чухал ач холбогдолтой юм. Энэ хэсэгт Архангай аймгийн Булган сумын 881⁵ өрхөөс түүвэрлэн авсан 150 өрхийн хүн ам зүйн мэдээллийг авч үзье.


Судалгаанд өрхийн гол гишүүд хамрагдсан буюу нийт 150 иргэний 77 нь өрхийн тэргүүн, 73 нь эхнэр эсвэл нөхөр байв. Энэ нь уг түүвэр судалгаагаар **тухайн өрхийн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв цуглуулах боломжийг бүрдүүлсэн байна**. Түүнчлэн, 150 иргэний 50% буюу 75 нь эмэгтэй, үлдсэн 75 нь эрэгтэйчүүд байсан нь **мэдээлэл цуглуулалтад жендэрийн тэгш байдлыг хангасан байлаа**.

Насны бүтцийн хувьд хамгийн багадаа 22 настай, хамгийн ихдээ 66 настай, дунджаар 41 насны 150 иргэн судалгаанд хамрагджээ. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны ашигладаг насны ангиллаар судалгаанд хамрагдсан иргэдийн насны ангиллын хистограммыг Дүрс 3-д үзүүлэв. **Нийт иргэдийн 74.0% буюу дөрвөн иргэн тутмын гурав нь 30-49 насны иргэн байна**. 20-29 насны иргэд харьцангуй цөөн буюу нийт түүврийн 10.7%-ыг бүрдүүлсэн байна. Ахмад буюу 50-аас дээш насны иргэд нийт түүврийн 15.3%-ыг бүрдүүлжээ.

Дүрс 3. Насны ангиллын хистограмм, n=150



Дүрс 4. Гэрлэлтийн байдал, хүйсээр, n=150



Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэрлэлтийн байдалд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Дүрс 4-д гэрлэлтийн байдлыг хүйсээр ялган дүрсэллээ. Судалгаанд огт гэрлээгүй эмэгтэй болон бэлэвсэн эрэгтэй хүн оролцоогүй байна. Харин судалгаанд хамрагдсан 75 эрэгтэйчүүдийн 5.3% нь гэрлээгүй байна.

⁵ (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2020)

Иймд эмэгтэйчүүд гэрлэлтээ батлуулсан байх магадлал өндөр байхад эрэгтэйчүүд гэрлэлтээ батлуулаагүй байх магадлалтай байна.

Ам бүлийн хувьд ганцаараа амьдардаг нэг өрх байсан бол хамгийн ихдээ 8 ам бүлтэй айл байна. Судалгаанд оролцогч өрхүүд дундажаар 4-5 ам бүлтэй, 2-3 хүүхэдтэй, өрхийн тэргүүн эсвэл гол орлого ологч энэ нутагтаа 30 жил амьдарч байгаа өрхүүд судалгаанд хамрагджээ. Судалгаанд хамрагдсан өрхийн нийт гишүүдийн 95.8% нь халх, үлдсэн 4.2% нь өөлд, хотон, дархадууд байна. Дөрвөд, казак, буриад үндэс, угсаатан судалгаанд хамрагдаагүй байна.

660 иргэний дийлэнх олонх буюу 74.2% нь буддын шашин шүтдэг. Харин тэдний 22.5% нь ямар нэгэн шашин шүтдэггүй бол үлдсэн 3.3% нь бөө, христ, исламын шашин шүтдэг байна.

Ихэнх өрх жилийн дөрвөн улиралд нүүдэллэж амьдардаг байна. Нийт 150 өрхийн 106 өрх буюу дунджаар 70.7% нь өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаанд тус тус нэг нэг удаа, жилд нийт дөрвөн удаа нүүдэллэсэн байна. Дунджаар тэдний 13.3% нь жилд найман удаа, 3.8% нь жилд арван хоёр ба түүнээс олон удаа тус тус нүүдэллэжээ. Түүнчлэн сүүлийн 12 сарын хугацаанд отор хийсэн өрх нийт өрхийн 56%-ыг эзэлж байна. Харин дунджаар нийт өрхийн 12.2% нь нүүдэл хийгээгүй суурин амьдардаг өрх байна.

Төслийн суурь болон эцсийн үнэлгээнд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн дотор эмзэг бүлэгт хамрагдах гишүүдийн тоо, эзлэх хувийг Хүснэгт 2-д харуулав. Суурь судалгаанд хамрагдсан 150 өрхийн 590 гишүүдийн дөрвөн нь өнчин иргэн, 19 бэлэвсэн иргэн байсан бол эцсийн үнэлгээнд нэг өнчин иргэн, зургаан бэлэвсэн иргэн оролцов. Харин суурь судалгаатай харьцуулахад эцсийн үнэлгээнд хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн тоо, таваас доош насны хүүхдийн эндэгдлийн тоо өссөн байна. Нийт дүнгээр харахад, эдгээр эмзэг бүлэгт хамрагдах иргэдийн тоо суурь судалгаанд 34 байсан бол эцсийн үнэлгээнд 38 болсон байна. Гэвч эцсийн үнэлгээнд хамрагдсан өрхийн гишүүдийн тоо олон байсан тулд эмзэг бүлгийн иргэдийн нийт иргэдийн тоонд эзлэх хувь буурсан дүнтэй гарчээ.

Хүснэгт 2. Нийт иргэний тоонд эмзэг бүлэгт хамаарах иргэдийн тооны эзлэх хувь

№	Эмзэг бүлэг	Суурь үнэлгээ, n=590		Эцсийн үнэлгээ, n=660	
		Тухайн бүлэгт хамрагдах иргэдийн тоо	Эзлэх хувь	Тухайн бүлэгт хамрагдах иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Өнчин	4	0.68%	1	0.15%
2	Бэлэвсэн гишүүн	19	3.22%	6	0.91%
3	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүн	11	1.86%	21	3.18%
4	5-аас доош насны хүүхдийн эндэгдэл	0	-	10	-
	Нийт	34	5.75%	38	4.24%

Өрхийн гишүүдийн боловсролын байдал

Энэ хэсэгт өрхийн гишүүдийн боловсролын байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг суурь онтой харьцуулж үзье.


Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байв. Дүрс 5-д үзүүлсэн хистограммаас харахад бакалавр болон түүнээс дээш зэргийн боловсролтой иргэд нийт түүврийн 6%-ийг л бүрдүүлж, үлдсэн 94.0% нь бакалаврын бус зэргийн, техник, мэргэжлийн боловсрол болон түүнээс доош түвшний боловсролтой байна. Тухайлбал, нийт 150 иргэний 25 иргэн буюу 16.7% бүрэн дунд, 87 иргэн буюу 58.0% суурь, 22 иргэн буюу 14.7% бага, хоёр иргэн буюу 1.3% нь боловсролгүй байна.

Дүрс 5. Боловсролын түвшнээр хистограмм, n=150



Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн боловсролын түвшинд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Дүрс 6-д боловсролын түвшинг хүйсээр ялган дүрсэллээ. Боловсролын түвшний хувьд нийт иргэдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байгаагийн дотор эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд боловсролгүй, эсвэл бага, дунд боловсролтой байх нь нийтлэг байна. Эсрэгээрээ, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд арай илүү боловсролтой байгаа нь Дүрс 6-аас харагдаж байна.

Дүрс 6. Боловсролын түвшин, хүйсээр, n=150




Эцсийн үнэлгээний хувьд өрхийн насанд хүрсэн гишүүдийн дотор бага болон түүнээс доош (тав болон түүнээс доош анги) боловсрол эзэмшсэн гишүүнтэй 44 өрх байв. Энэ нь нийт судалгаанд хамрагдсан өрхийн 29.3% байгаа нь өрхийн насанд хүрсэн гишүүдийн боловсрол харьцангуй доогуур байгааг бататгана. Суурь судалгааны хувьд энэ үзүүлэлт 28.0% байжээ. Харин сургууль завсардсан сургуулийн насны (6-14 нас) хүүхэдтэй хоёр өрх эцсийн үнэлгээнд хамрагдсан нь суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад бага байна.

Өрхийн гишүүдийн эрүүл мэндийн байдал

Суурь судалгаанд хамрагдсан иргэдийн 78% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байсан бол эцсийн үнэлгээнд 98% нь эрүүл мэндийн даатгалд хамрагджээ.

Өрхийн гишүүдийн биеийн өндөр болон жингийн мэдээллийг өрх тус бүрээс судалгаа авахдаа цуглуулж, биеийн жингийн индекс (БЖИ) тооцов. Насанд хүрэгчдийн БЖИ-ээр тухайн өрхийн хоол тэжээлийн байдлыг төлөөлөн илэрхийлэх боломжтой гэж суурь судалгаанд үзсэнийг эцсийн судалгаанд мөн ашиглав. ОХЯИ нь илүүдэл жинтэй насанд хүрэгчид болон хүүхдүүдийг хоол тэжээлийн дутагдалд орсонд тооцдоггүй. Насанд хүрэгчдийн БЖИ 18.5-аас доош бол хоол тэжээлийн дутагдалд орсон гэж үздэг. Дүрс 7-д эцсийн судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн БЖИ-ээр илэрхийлсэн эрүүл мэндийн байдлыг үзүүлэв.

Дүрс 7. Өрх тус бүрийн сонгогдсон гишүүдийн БЖИ, n=150



БЖИ-ийн үзүүлэлтээс харахад оролцогчдын 54% нь жингийн илүүдэлтэй, таргалалттай байна. БЖИ-ийн үзүүлэлтээр нийт өрхийн 45% эрүүл байгаа нь суурь судалгааны үзүүлэлт болох 13%-тай харьцуулахад сайн үзүүлэлт байна. Түүнчлэн суурь судалгаанд нийт иргэдийн 3% туранхай гарсан бол эцсийн үнэлгээнд 1% нь туранхай буюу хоол тэжээлийн хомсдолд орсон гэж үнэлэгджээ.

Өрхийн амьдралын нөхцөл

ОХЯИ нь амьдралын нөхцөлийг тодорхойлоход зургаан индикаторыг авч үздэг. Үүнээс гурван индикатор нь эмэгтэйчүүдэд илүү нөлөөлдөг хүчин зүйлс болох цэвэр ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж, цэвэр түлшний хэрэглээ зэрэг эрүүл мэнд болон амьжиргааны түвшинтэй холбоотой байдаг. Хоёр индикаторт нь өрхийн орон сууцны чанарыг суурь түвшинд харуулахуйц цахилгаан эрчим хүч болон цахилгаан хангамжийн төрөл, шалны материалын хүртээмж зэрэг багтдаг. Сүүлчийн индикатор нь радио, дүрст, утас, унадаг дугуй, мотоцикл, суудлын болон ачааны машин, хөргөгч зэрэг өмч хөрөнгийг орлуулан тооцох боломжтой өргөн хэрэглээний бараанууд (Alkire Sabina, et al., 2011) хамардаг.

Ундны цэвэр ус. Ундны цэвэр усны хүртээмжийн хувьд цэвэр усаар хангагдаагүй болон цэвэр ус авахаар гэрээсээ гарахад 30-аас дээш минут зарцуулах шаардлага гардаг бол цэвэр усны хомсдолтойд тооцдог. Ундны цэвэр усанд хоолойн ус, нийтийн цорго, цооног, шахуурга, хамгаалалттай худаг, хамгаалагдсан булаг шанд, борооны ус зэрэг ордог. Босго шугамын дагуу 3% нь цэвэр ус хэрэглэдэг байсан бол эцсийн үнэлгээгээр 34.7% нь цэвэр усаар хангагддаг болжээ. Өөрөөр хэлбэл, эцсийн үнэлгээнд оролцсон нийт 150 өрхийн 34.7% нь цэвэр усаар хангагдаж, үлдсэн 65.3% нь амьжиргааны түвшний индикаторын ундны усны үзүүлэлтээр хангалтгүй буюу хомсдолтойд тооцогдож байна.

Ариун цэврийн нөхцөл байдал. Тухайн өрх ариун цэврийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжгүй эсвэл бие засах газраа хуваалцдаг бол сайжруулсан ариун цэврийн байгууламжийн дутагдалтай гэж үздэг. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид татуургатай суултуурын болон явган жорлон, бусадтай хуваалцаагүй агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон зэрэг орно. Үүнээс гадна өрх өөрсдийн нөхцөл байдалд сэтгэл ханамжгүй тохиолдолд үүнийг ариун цэврийн гачигдал дутагдалтайд тооцно. Босго шугамын дагуу суурь үнэлгээнд өрхүүдийн зөвхөн 5% нь сайжруулсан ариун цэврийн байгууламжийг ашиглаж байсан бол эцсийн үнэлгээнд 60% нь ашиглаж байна. Тодруулбал, эцсийн үнэлгээнд оролцсон өрхийн 40% нь амьжиргааны түвшний индикаторын ариун цэврийн үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой байна.

Цэвэр түлш: Тухайн өрх мод, нүүрс эсвэл аргал түлдэг бол цэвэр түлшний гачигдал хомсдолтойд тооцогддог. Суурь үнэлгээнд оролцсон өрхийн 99%, эцсийн үнэлгээнд оролцсон өрхийн 98% тус тус амьжиргааны түвшний индикаторын цэвэр түлшний үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой гарсан.

Гэр байр, орон сууцны шал: Суурь судалгаанд оролцсон өрхийн дийлэнх (85%) нь гэр, 2% нь байшин, 13% нь гэр болон байшинтай байв. Байшин болон гэрийн хананы гол материал нь мод байсан бол шалны хувьд ус нэвтэрдэггүй хулдаас байсан. Өрхийн тавны нэг (21%) нь шалгүй буюу нягтаршуулсан шороо эсвэл аргал дэвссэн шалтай байсан. Үүнтэй холбоотойгоор өрхийн 21% нь амьжиргааны түвшний индикаторын шалны үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой байна.

Харин эцсийн үнэлгээнд оролцсон нийт өрхийн 90% гэрт, 8% байшинд, 2% нь орон сууцанд амьдарч байв. Амьдарч буй сууцны чанарыг тэдний 4% маш сайн, 31.33% сайн, 62.0% дундаж, 2.67% муу гэж үнэлжээ.

Цахилгаан: Эцсийн үнэлгээнд нэг өрхөөс бусад нь тог цахилгааны хангамжтай байсан. Тэдний 11.3% нь төвлөрсөн цахилгааны системд, 1.3% дизель станц, бензинээр ажилладаг генератор, 70.7% нь нарны эрчим хүч, 16.0% бага оврын цахилгаан үүсгүүр, 0.7% нь лаа тус тус ашигладаг байна. Эндээс харахад суурь үнэлгээнд хоёр өрх амьжиргааны түвшний индикаторын тог цахилгааны үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой байсан бол эцсийн үнэлгээнд ганц өрх энэ төрлийн гачигдалтай гарсан байна.

Өмч хөрөнгийн эзэмшил: Өрхүүд нэгээс дээш тооны радио, дүрст, утас, унадаг дугуй, мотоцикл, хөргөгч, угаалгын машин, мөнгөн аяга, эсвэл ногооны хүлэмж (машин эсвэл тракторгүй) эзэмшдэггүй бол өмч хөрөнгийн гачигдал хомсдолтойд тооцогддог. Ихэнх өрх нэгээс олон тооны өргөн хэрэглээний бараа эзэмшиж байсан. Өрхүүдийн хамгийн их эзэмшиж байсан бараанд гар утас, зурагт, хөргөгч гурав багтаж байна. Үүнээс гадна, өрхүүдийн 58.7% нь автомашин, 41.3% суудлын машинтай, дийлэнх буюу 70% нь мотоциклтой байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт

Төсөл хэрэгжсэнээр өрхийн нийгэм, эдийн засгийн байдалд ямар өөрчлөлт гарсныг судалгааны баг (1) ОХЯИ тооцож, суурь оны индекстэй харьцуулан (2) өрхөөс авсан асуулга, бусад оролцогч талуудаас авсан ярилцлагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар төслийн нийгэм, эдийн засгийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдийг үнэлж, энэ хэсэгт тайлагналаа.

ОХЯИ тооцоололт, суурь оны индекстэй харьцуулсан шинжилгээ

Эцсийн шатны судалгааны хүрээнд ОХЯИ-ийг 150 өрхийн түүвэр өгөгдлийг ашиглан тооцлоо. Уг индекс тооцоололд аргачлалын дагуу боловсрол (суралцсан жил, сургуульд хамрагдалт), эрүүл мэнд (нялхасын эндэгдэл, хоол хүнсний шим тэжээл), амьжиргааны түвшин (цахилгаан, ундны ус, ариун цэврийн нөхцөл, гэр, байр, орон сууцны шал, хоол унд хийх түлш, өмч хөрөнгийн эзэмшил) гэсэн гурван бүлэг, 10 дэд үзүүлэлтийг түүврийн асуулгын харгалзах асуултуудад үндэслэн 0, 1 гэсэн утга оноон кодолж, олон хэмжээсийн хувьд тухайн өрхийн ядууралд өртсөн эсэхийг ядуурлын оноог (deprivation score) тооцох замаар тодорхойлов. Уг онооны хувьд 10 дэд үзүүлэлт тус бүрд 0, 1 гэсэн утга оноохдоо суралцсан жилийн хувьд тухайн өрхөд бага боловсрол буюу таван жилийн боловсрол эзэмшээгүй хүн байдаг бол 1, сургуульд хамрагдалтын хувьд хэрвээ тухайн өрхөд 6-14 насны сургууль завсардсан хүүхэд байдаг бол 1, таваас доош насны хүүхэд эндсэн тохиолдол байгаа бол 1 гэсэн оноог тус тус өгнө. Эдгээр 10 дэд үзүүлэлт тус бүрийн аль нэг дээр 1 гэсэн оноо авч байгаа бол тухайн өрх олон хэмжээсийн хувьд ядууралд өртсөн гэсэн үг.

Дараах хүснэгтэд ядуурлын онооны үр дүнг харуулсан бөгөөд түүвэрт байгаа 150 өрхийн хувьд 10 дэд үзүүлэлт тус бүрээр 1 гэсэн оноо авсан өрхийг тоог харуулсан болно. Жишээлбэл, эцсийн шатны судалгаагаар 44 өрхөд бага ангийн боловсрол эзэмшээгүй хүн байгаа гэдгийг хүснэгтээс харах боломжтой.

Хүснэгт 3. Ядууралд өртсөн өрхийн нөхцөл байдал

Үзүүлэлтүүд	Ядууралд өртсөн өрхийн тоо		Нийт өрхөд эзлэх хувь	
	Суурь шат	Эцсийн шат	Суурь шат	Эцсийн шат
Боловсрол				
Суралцсан жил	42	44	28%	29.3%
Сургуульд хамрагдалт	5	2	3%	1.3%
Эрүүл мэнд				
Нялхасын эндэгдэл	0	7	0%	4.7%
Хоол хүнсний шим тэжээл	5	2	3%	1.3%
Амьжиргааны түвшин				
Цахилгаан	2	1	1%	0.7%
Ундны ус	145	98	97%	65.3%
Ариун цэврийн нөхцөл	143	60	95%	40%
Гэр, байр, орон сууцны шал	32	85	21%	56.7%
Хоол унд хийх түлш	149	147	99%	98%
Өмч хөрөнгийн эзэмшил	54	0	36%	0%

Суурь судалгаатай харьцуулахад эцсийн шатанд ядууралд өртсөн өрхийн тоо суралцсан жил, нялхасын эндэгдэл, гэр, байр, орон сууцны шал гэсэн дэд үзүүлэлтүүдийн хувьд өссөн бол сургуульд хамрагдалт, хоол хүнсний шим тэжээл, цахилгаан, ундны ус, ариун цэврийн нөхцөл, хоол унд хийх түлш, хөрөнгийн эзэмшил гэсэн дэд үзүүлэлтүүдийн хувьд буурчээ.

Олон хэмжээст ядуурлын индекс нь олон хэмжээсийн хувьд ядуу хүмүүсийн нийт хүнд эзлэх хувь (H), олон хэмжээст ядуурлын эрчимжилт (A) гэсэн хоёр индексийн үржвэрээр тодорхойлогдоно.

$$MPI = H \cdot A$$

Дээрх өрх бүрийн ядуурлын оноо, өрхийн ам бүлийн тоог тус тус ашиглан олон хэмжээст ядуурлын хамрах хүрээний индекс (H)-ийг тооцвол дараах үр дүн гарна.

$$H = q/n = 151/660 = 0.229$$

Энд n нийт хүний тоо бөгөөд өрх бүрийн ам бүлийн тооны нийлбэрээр тооцох бол q нь уг ОХЯИ-ийн аргачлалын дагуу ядууралд өртсөн хүний тоо бөгөөд үүнийг тооцохдоо ядууралд өртсөн өрх бүрийн ам бүлийн тоог нэмэх замаар тооцно.

Одоо олон хэмжээст ядуурлын эрчимжилт (A)-ийг тооцъё. Үүний ядуурлын оноо нь $1/3$ -ээс бага байх өрхүүдийн ядуурлын оноог тэг засварлах замаар дараах томъёогоор уг дэд индексийг тооцвол

$$A = \left(\sum_{i=1}^n c_i(k) \right) / q = 55.111/151 = 0.365$$

гэсэн үр дүн гарна. (Энд хийгдэж буй бүх тооцооллыг Стата (Stata) программ Dofile-ыг ажиллуулан, харах боломжтой)

Дээрх хоёр дэд индексийн тооцооллын үр дүнг ашиглан эцсийн шатны судалгааны ОХЯИ-ийг тооцъё.

$$MPI = H \cdot A = 0.229 \cdot 0.365 = 0.084$$

Архангай аймгийн Булган сумын хувьд эцсийн шатны ОХЯИ-ийн үр дүнг суурь шатныхтай харьцуулж, доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 4. ОХЯИ-ийн харьцуулалт

Судалгааны шат	Олон хэмжээст ядуурлын индекс ($MPI = H \cdot A$)	Олон хэмжээсийн хувьд ядуу хүмүүсийн нийт хүний тоонд эзлэх хувь (H)	Олон хэмжээст ядуурлын эрчимжилт (A)	Ядууралд өртсөн хүний тоо (q)
Суурь	0.115	0.297	0.389	175
Эцэс	0.084	0.229	0.365	151

Дээрх хүснэгтээс харвал ОХЯИ суурь шатанд 0.115 байсан бол эцсийн шатанд 0.084 болж, 0.031 функтээр буурчээ. Тодруулбал, олон хэмжээсээр тооцсон ядуу хүмүүсийн нийт хүний тоонд эзлэх хувь суурь шатнаас эцсийн шатанд 0.297-оос 0.229 болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, суурь шатанд судалгаанд оролцсон нийт хүний 29.7% нь ядуу байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 22.9% болж, буурчээ. Олон хэмжээст ядуурлын эрчимжилт суурь шатнаас эцсийн шатанд 0.389-өөс 0.365 болж, 0.024 функтээр мөн буурсан буюу суурь шатанд ядууралд өртсөн өрхүүдийн 38.9% нь нийт үзүүлэлтийн хувьд гачигдалтай байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 36.5% болж буурсан гэсэн үг. Ийнхүү дэд хоёр индекс хоёул мэдэгдэхүйц буурсан нь ОХЯИ эцсийн байдлаар буурахад нөлөөлөв.

Эндээс дүгнэвэл суурь шатнаас эцсийн шатны хооронд төслийн хэрэгжилтийн дүнд олон хэмжээст ядуурлын индекс буурсан нь түүвэрт хамрагдсан өрхүүдийн хувьд амьдрал чанар ерөнхий утгаараа сайжирчээ. Гэхдээ ОХЯИ тооцоход ашиглаж буй 10 дэд үзүүлэлтийн 7 үзүүлэлт сайжирсан буюу олон хэмжээсийн хувьд ядууралд өртсөн өрхийн тоо буурсан, харин гурван үзүүлэлтийн хувьд муудсан дүнтэй байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. ОХЯИ-ийн хоёр бүрэлдэхүүн индекс хоёулаа буурсан нь түүвэрт хамрагдсан өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал сайжирсныг ахин батлан харуулна.

Нийгэм, эдийн засгийн үр дүнг илэрхийлэх ОХЯИ-ээс бусад үзүүлэлтүүдийн үнэлгээ

Энэ хэсэгт ОХЯИ-ийн үр дүнг анхдагч, хоёрдогч тоон болон чанарын мэдээллүүдээр баяжуулан Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлэх зорилготой. Өмнөх хэсэгт дурдсанаар ОХЯИ суурь онд 0.115 байсан бол эцсийн үнэлгээгээр 0.084 болж буурсан байна. Тодруулбал, ядуурлын индекс буурна гэдэг нь суурь онтой харьцуулахад тухайн орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал сайжирсныг илтгэнэ. Тэгвэл индексийн тооцоололд ашиглагдаагүй бусад хувьсагчдыг ашиглан иргэдийн сайн сайхан байдлыг үнэлж, энэ хэсэгт тайлагнана.

Өрхийн орлого, орлогын эх үүсвэр, орлогын хүрэлцээтэй байдал


Эцсийн үнэлгээнд оролцсон өрхийн дийлэнх нь буюу 80% нь өөрсдийгөө дундаж давхрагад хамааруулсан бол 8% нь дундаас дээгүүр, 12% нь дундаас доогуур давхрагад хамаарна гэж үнэлжээ. Амьжиргааг хэмжих гол үзүүлэлтүүдийн нэг өрхийн орлого, түүний бүтэц сүүлийн гурван жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг Хүснэгт 5-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан 150 өрх сүүлийн гурван жилд дунджаар 8,452,628 төгрөгийн орлого олсны 72.15%-ыг үндсэн ажил, эх сурвалжаас, 13.5%-ыг нэмэлт орлогоос, 19.4%-ыг нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжээс, 6.7%-ыг байгалийн нөөц ашиглалтаас, үлдсэн багахан хувийг ан, амьтны ашиглалтаас тус тус бүрдүүлжээ. Орлогын эх үүсвэр бүрээр ялгаж харвал гурван жилийн турш үндсэн ажил, эх сурвалжаас олсон орлого, нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн орлого, байгалийн нөөц ашиглалтаас олсон орлогууд эрчимтэй нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Өрхийн жилийн орлого, төгрөгөөр


№	Орлогын эх үүсвэр	2018 он	2019 он	2020 он	Гурван жилийн дундаж	Эзлэх хувь
1	Үндсэн ажил, эх сурвалж	5,518,467	5,604,533	7,174,480	6,099,160	72.2%
2	Нэмэлт нийт орлого	1,433,333	1,144,000	838,333	1,138,556	13.5%
3	Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмж	1,177,827	1,308,067	2,444,260	1,643,384	19.4%
4	Ан, амьтны ашиглалт (тарвага, бугын эвэр, хүдрийн заар гэх мэт)	1,000	-	0.013	333	0.0%
5	Байгалийн нөөц (мод, самар, жимс гэх мэт) ашиглалт	322,001	271,833	1,101,867	565,234	6.7%
Жилийн нийт орлого		8,452,628	8,328,433	11,558,940	8,452,628	100.0%

Төслийн суурь болон эцсийн үнэлгээн дэх өрхийн сарын дундаж орлогын давтамж, дундаж орлого, медиан орлогуудын харьцуулалтыг Дүрс 8 болон Дүрс 9-д тус тус үзүүлэв. Суурь онд судалгаанд хамрагдсан нийт 150 өрхийн 57% нь 500'000-аас бага орлоготой байсан бол төслийн эцсийн үнэлгээнд хамрагдсан мөн 150 өрхийн 31% нь 500'000-аас доош орлоготой байна. Түүнчлэн суурь онтой харьцуулахад төслийн эцсийн онд өндөр орлоготой өрхийн эзлэх хувийн жин өссөн байна. Өрхийн сарын медиан орлого суурь онд 448'750 төгрөг байсан бол эцсийн онд 714'250 төгрөг болж, өссөн төдийгүй өрхийн дундаж орлого суурь онд 553'837 төгрөг байснаа төгсгөлийн онд 963'245 төгрөг болж, нэмэгдсэн байгаа нь **сүүлийн гурван жилийн хугацаанд өрхийн амьжиргаа дээшилснийг илтгэнэ.**

Дүрс 8. Суурь болон төгсгөлийн оны өрхийн сарын орлогын давтамж



Дүрс 9. Суурь болон төгсгөлийн оны өрхийн сарын дундаж болон медиан орлогын харьцуулалт




Төслийн үндсэн таван зорилтын нэг нь төсөлд хамрагдсан өрхийн орлого олох эх үүсвэрийн тоог нэмэгдүүлэх, баталгаат ажлын байр бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэх явдал байв. Эцсийн үнэлгээнд хамрагдсан 150 өрх дунджаар 4-5 ам бүлтэй байгаагаас тэдний 2-3 нь орлого олдог байна. Өөрөөр хэлбэл, **өрхийн гишүүдийн 50%-60% орлого олдог** байна. Мөн өрхийн дийлэнх буюу 102 өрх хоёр болон түүнээс олон орлогын эх үүсвэртэй байгааг Хүснэгт 6-аас харж болно.

Хүснэгт 6. Өрхийн орлогын эх үүсвэрийн тоо

Орлогын эх үүсвэрийн тоо	Өрхийн тоо	Эзлэх хувь
Нэг эх үүсвэртэй	48	32%
Хоёр эх үүсвэртэй	79	53%
Гурван эх үүсвэртэй	18	12%
Дөрвөн эх үүсвэртэй	5	3%
Нийт	150	100%

Эцсийн үнэлгээний өрхийн судалгаанд оролцсон 150 өрхөөс дунджаар 63.2% нь өрхийн аж ахуй эрхэлдэг ба тэд бараг бүгд мал аж ахуй, туслах аж ахуй эрхэлдэг нь Дүрс 10-аас харагдаж байна. Тодруулбал, нийт өрхийн 96.7% мал аж ахуй, 98.7% туслах аж ахуй, 22.7% газар тариалан, 34.7% мод бэлтгэл, байгалийн нөөц ашиглалтаас орлого олжээ.

Дүрс 10. Өрхийн аж ахуй эрхлэлтийн байдал, n=150



Сүүлийн гурван жилийн хугацаанд нийт өрхийн 20% хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулж, хэрэгцээгээ хангах боломжтой байсан ба тэдний 43.3% нь хэрэгцээнээсээ илүү гарсан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, орлого олдог байжээ. Тодруулбал, **сүүлийн гурван жилд өрх хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулж, хэрэгцээгээ хангахаас гадна зах зээлд нийлүүлж, амьжиргаагаа дэмждэг болжээ.**

Суурь 2018 онтой харьцуулахад 2020 онд өрхийн амьжиргаа сайжирсныг илтгэх өөр нэг үзүүлэлт нь өрхийн орлогын хүрэлцээтэй байдлын талаарх иргэдийн үнэлгээ юм. 2018 оны суурь судалгаанд хамрагдсан нийт 150 өрхийн 43% нь өрхийн орлого өдөр тутмын суурь хэрэгцээндээ дөнгөж хүрдэг, эсвэл хүрэлцдэггүй гэж хариулж байсан бол 2020 оны судалгаанд хамрагдсан 150 өрхийн 29.3% нь ингэж хариулсан байна. Харин 2018 онтой харьцуулахад 2020 оны судалгаанд өрхийн орлого өдөр тутмын хэрэгцээгээ хангаад ойр зуурын хувцас хунар зэрэгт хүрэлцдэг, хэрэгцээнээсээ илүүчилж, хуримтлал бий болгож чаддаг өрхийн эзлэх хувь өссөн байгаа нь **өрхийн амьжиргаа сайжирсныг илтгэнэ.** (Дүрс 11)

Дүрс 11. Өрхийн орлогын хүрэлцээ, n=150



Нөхөрлөлөөс хүртэх үр өгөөж

Эцсийн үнэлгээнд хамрагдсан 150 өрхийн 142 өрх буюу 94.7% байгалийн нөөцийн хамтын менежменттэй нөхөрлөлийн гишүүн байв. Тэд нөхөрлөлийн гишүүн болсноор олон төрлийн үр өгөөжийг хүртдэг тухайгаа судалгааны багийнханд мэдэгдэж байлаа. Харин нөхөрлөлийн гишүүн байснаараа сөрөг үр дагавар бараг байгаагүйг тэд онцолсон юм. Хүснэгт 7-аас харахад өрхүүд нөхөрлөлийн гишүүн болсноор дундын хуримтлалын бүлэгт хамрагдаж, ноогдол ашиг авах замаар болон ойн цэвэрлэгээ хийж, байгальд ээлтэйгээр амьжиргаагаа амьжиргаагаа дээшлүүлсэн гэж хариулсан өрхийн эзлэх хувь өндөр байна. Удаад нь бизнес төлөвлөгөө, төсөл бичиж, тоног төхөөрөмжийн болон бусад дэмжлэг авч, амьжиргаагаа дээшлүүлж чадсан, үзэсгэлэн худалдаанд оролцож, амьжиргаагаа дээшлүүлсэн гэж хариулсан байна.

Хүснэгт 7. Нөхөрлөлийн гишүүд нөхөрлөлөөс хүртэх үр өгөөж, n=142


№	Үр өгөөж	Өрхийн тоо	Эзлэх хувь
1	Нөхөрлөлийн дундын хуримтлалын бүлэгт хамрагдаж, ноогдол ашиг авах замаар амьжиргаагаа дээшлүүлсэн.	100	70.4%
2	Ойн цэвэрлэгээ хийж, байгальд ээлтэйгээр амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой болсон.	92	64.8%
3	Бизнес төлөвлөгөө, төсөл бичиж, тоног төхөөрөмжийн болон бусад дэмжлэг авч, амьжиргаагаа дээшлүүлж чадсан.	82	57.7%
4	Үзэсгэлэн худалдаанд оролцож, амьжиргаагаа дээшлүүлсэн.	32	22.5%

Нөхөрлөлийн гишүүн болсноор өрхийн амьжиргаанд дэмжлэг болоод зогсохгүй нэгдсэн журмаар бэлчээрээ зүй зохистой ашигладаг, ойгоо хамгаалдаг, гол усаа цэвэрлэдэг болсон зэрэг байгаль орчноо хамтын хүчээр хайрлан хамгаалж, нөөцийг зүй зохистой ашигладаг болсноос гадна нутгийн иргэдийн хамтын ажиллагаа сайжирсан байна. Эндээс **өрхүүд байгалийн нөөцийн хамтын менежмент бүхий нөхөрлөлийн гишүүн болох нь өндөр үр өгөөжтэй болох нь харагдаж байна.**


Нөхөрлөлийн дундын хуримтлалын сан, түүний үр өгөөж

Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах зорилготой энэхүү төслийн хүрсэн гол үр дүнгийн нэг нь нөхөрлөл байгуулж, нөхөрлөлийн дундын хуримтлалын сан байгуулсан явдал юм. Нийт судалгаанд хамрагдсан 150 өрхийн 140 өрх буюу 93% нь нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагдаж, сард дунджаар 47'045 төгрөг санд нийлүүлдэг байна. Тэдний 36.4% сард 20'000 төгрөгөөс бага, 84.3% нь сард 60'000 төгрөгөөс бага дүнгээр санд хуримтлал хийдэг гэжээ. (Дүрс 13)

Дүрс 12. Нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагддаг эсэх, n=150




Дүрс 13. Дундын хуримтлалын санд сард хуримтлуулдаг мөнгө, төгрөгөөр, n=140



Дундын хуримтлалын бүлэгт хамрагдсанаараа нийт өрхийн дунджаар 87.7% нь үр өгөөж хүртсэн байна. Дундын хуримтлалын бүлэгт хамрагдсанаар тэдний 91.4% нь барьцаагүй, бага хүүтэй зээл авах боломжтой болж, 87.9% нь амьжиргаагаа дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж чадсан бол 82.1% нь санхүүгийн мэдлэг, санхүүгийн сахилга баттай болжээ. Түүнчлэн нөхөрлөлийн гишүүдийн хамтын ажиллагаа сайжирсан гэж хуримтлалын бүлгийн гишүүн 140 өрхийн 89.3% үзсэн байна. Эндээс дүгнэхэд **өрх сарын дундаж орлого болох 963'245 төгрөгийн 5 (сард дунджаар 47'045 төгрөг) хүрэхгүй хувийг хуримтлалд нийлүүлж, хуримтлалын бүлэгт хамрагдсан ихэнх өрх үр өгөөж хүртэж чаддаг байна.**

Дүрс 14. Дундын хуримтлалын бүлэгт хамрагдсанаар үр өгөөж хүртсэн өрхийн эзлэх хувь, n=140




Сүүлийн гурван жилд өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт, иргэдийн сэтгэл ханамж

Амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлтийг тоон үзүүлэлтээр шинжлэхээс гадна нутгийн иргэд амьдралдаа хэр сэтгэл хангалуун байгааг өөрсдөөр нь үнэлүүлж, амьжиргаагаа хэрхэн сайжирсан гэж үзэж байгааг тандан, тодруулж, Дүрс 15 болон Хүснэгт 8-д нэгтгэн үзүүлэв. Судалгаанд хамрагдсан нийт 150 өрхөөс өөрийн амьдралдаа сэтгэл ханамжгүй өрх алга. Тэдний 14.0% амьдралдаа маш их сэтгэл

ханамжтай, 65.3% сэтгэл ханамжтай, үлдсэн нь дундаж гэж хариулснаас үзэхэд **дийлэнх өрх амьдралдаа сэтгэл хангалуун, аз жаргалтай байна.**

Дүрс 15. Өөрийн амьдралдаа сэтгэл хангалуун өрхийн эзлэх хувь, n=150



Сүүлийн гурван жилийн хугацаанд өрх өөрийн амьжиргаанд гарсан өөрчлөлтөө үнэлсэн байдлаас үзэхэд нийт өрхийн 40.7% нь амьжиргаа дээшилсэн, 50.0% нь хэвэндээ, 14% нь дордсон гэж хариулсан байна. Амьжиргаа дордсон гэж хариулсан өрхийг нөхөрлөлийн гишүүн болон гишүүн бус байдлаар ялгаж харвал нөхөрлөлийн гишүүн бус өрхийн 25% нь амьжиргаа бага зэрэг эсвэл бүр дордсон гэж үнэлсэн байхад нөхөрлөлийн гишүүн өрхийн 8.5% нь бага зэрэг дордсон гэжээ. Нөхөрлөлийн гишүүн өрхийн амьжиргаа дээшилсэн болон хэвэндээ байсан хувь нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад өндөр байгаа тул **уг төсөл өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна гэж дүгнэх боломжийг үүсгэж байна.** (Хүснэгт 8)

Хүснэгт 8. Сүүлийн гурван жилд амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлт

№	Амьжиргааны түвшин	Нийт өрхийн тоо	Эзлэх хувь	Нөхөрлөлийн гишүүн өрхийн тоо	Эзлэх хувь	Нөхөрлөлийн гишүүн бус өрхийн тоо	Эзлэх хувь
1	Мэдэгдэхүйц дээшилсэн	9	6.0%	9	6.3%	0	0.0%
2	Бага зэрэг дээшилсэн	52	34.7%	49	34.5%	3	37.5%
3	Хэвэндээ	75	50.0%	72	50.7%	3	37.5%
4	Бага зэрэг доошилсон	13	8.6%	12	8.5%	1	12.5%
5	Бүр дордсон	1	0.7%	0	0.0%	1	12.5%
Нийт		150	100%	142	100%	8	100%

Түүнчлэн төслийн үр дүнд орон нутгийн иргэдийн амьжиргаа сайжирсан гэдгийг ярилцлагад хамрагдсан нөхөрлөлийн гишүүд, нөхөрлөлийн холбооны төлөөлөл мэдээллэж байлаа. Жишээ болгож өрх толгойлсон эрэгтэйчүүдийн төлөөлөл, нөхөрлөлийн гишүүн иргэний ярилцлагын хэсгийг Шигтгээ 1-д оруулав.

Шигтгээ 1. Нөхөрлөлийн гишүүд хамтран цагаан идээг өмнөхөөсөө ихээр үйлдвэрлэж, борлуулдаг болсон.

Төслөөс нөхөрлөлийн гишүүдийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгож, цагаан идээний тоног төхөөрөмж өгсөн. Хийсэн ааруулнууд маань 100% борлогддог. Манай нөхөрлөл цагаан идээгээр дагнадаг. Өмнө нь хувь хувиараа хийдэг байсан бол одоо нөхөрлөл болж хамтран ажилласнаар цагаан идээнийхээ төрлийг нэмж, ихээр үйлдвэрлэдэг болсон.

Өрх толгойлсон эрэгтэйчүүдийн төлөөлөл, нөхөрлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагаас

COVID-19 халдвараас сэргийлж, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой хугацаанд хязгаарласан Засгийн газрын бодлого иргэдийн амьжиргаанд мөн нөлөөлсөн байх магадлал өндөр. Сүүлийн гурван жилийн хугацаанд амьжиргааны түвшин мэдэгдэхүйц сайжирсан гэж үнэлсэн есөн өрхийн хоёр нь цар тахлаас шалтгаалсан гэсэн бол мөн хоёр нь олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд, хоёр нь өрхийн гишүүдийн ажил эрхлэлттэй холбоотой, бусад нь байгаль цаг уурын нөхцөл, өрхийн гишүүдийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй холбоотой гэж үзжээ. Олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд амьжиргаа мэдэгдэхүйц сайжирсан гэж хоёр өрх, бага зэрэг дээшилсэн гэж зургаан өрх үнэлсэн ба төсөл, хөтөлбөрөөс шалтгаалж, дордсон муудсан, эсвэл хэвэндээ байсан гэсэн хариулт нэг ч өрх өгөөгүй байна. Энэ нь **төсөл, хөтөлбөр орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр болсныг дахин баталж байна.**

Шигтгээ 2. Нөхөрлөлийн гишүүд хамтран цагаан идээг өмнөхөөсөө ихээр үйлдвэрлэж, борлуулдаг болсон.

Өнгөрсөн хавар нэг нөхөрлөл 7 сая төгрөгийн төсөл бичиж өгөөрэй гэж ЛАСН-ээс хэлсэн. Манайхан газар тариалантай ойрхон учраас газар тариалангийн багаж авч, түүгээрээ 20 га-д малын тэжээл тарьдаг болсон. Тоног төхөөрөмжтэй болсон учраас малын тэжээлээ худалдаж авахгүй, өөрсдөө тарих гэх мэтээр өөрчлөлт орж байна. Мөн цагаан идээгээ хийж үзэсгэлэн худалдаанд борлуулдаг.

Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас




ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨ, ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭ

ГУРАВ. ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Зорилт 1: Ховордож буй амьтан хамгаалал ба мониторинг

Судалгаанд оролцогчдоос зэрлэг амьтны тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд хэр өөрчлөгдсөнийг тодруулахад 44% нь сайжирсан, 9.3% нь муудсан, 46.7% өөрчлөлт байхгүй хэмээн үзэж байна. Зэрлэг амьтны тоо толгой буурсан хэмээн үзэж байгаа 9.3% нь зэрлэг амьтны тоо толгойг тодорхойлохдоо 28.6% нь их, 57.1% нь дунд, 14.3% нь бага үзэж байна. Зэрлэг амьтны тоо толгой буурсан хэмээн үзэж байгаа 14 оролцогч (9.3%) нөхөрлөлийн гишүүнчлэлээр харьцуулан үзэхэд Арцат 3, Баянбулаг 1, Наранбулаг 1, Буурал хангай 2, Тэххайрах 3, Жарантай 1, Наранбулаг 1, Өндөрхөтөл 1, Тэмээн чулууны 1 гишүүн буурсан хэмээн үзэж байна.

Дүрс 16. Зэрлэг амьтны тоо толгойн сүүлийн гурван жилийн нөхцөл байдал, n=150



Дүрс 17. Зэрлэг амьтны тоо толгойн сүүлийн гурван жилийн өсөлт, бууралтын түвшин, n=15



Хүдэр. Судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 40 өрх буюу 26.7% нь хүдрийг харсан ба үүнээс 26% нь амьдаар, 0.7% нь үхсэнээр харсан байна. Эдгээр 40 өрхийн 50% нь жилд нэг удаа, 40% нь заримдаа (2-12 удаа), 10% нь ойр ойрхон (жилд 13 ба түүнээс олон удаа) харсан байна. Хүдэр харсан иргэд сумын төвөөс дунджаар 59 км зайтай харсан бол, хамгийн багадаа 15 км, хамгийн ихдээ 70 км зайд харсан байна. Иргэдийн хувьд ажиглалтын камераас болон малд явж байхдаа ихэвчлэн хардаг байна. Мөн хүдэр байгаа эсэхийг мөрөөр ихэвчлэн таньдаг байна. Нийт хүдэр харсан 40 оролцогчийн 90% нь хүдрийг таньж, тодорхойлж мэддэг бол, 10% нь таньж, тодорхойлж мэддэггүй байна.


Шонхор. Судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 41 өрх буюу 27.4% нь шонхор харсан ба үүнээс 26.7% нь амьдаар, 0.7% нь үхсэнээр харсан байна. Эдгээр 41 өрхийн 31.7% нь жилд нэг удаа, 41.5% нь заримдаа (2-12 удаа), 26.8% нь ойр ойрхон (жилд 13 ба түүнээс олон удаа) харсан байна. Шонхор харсан иргэд сумын төвөөс дунджаар 35 км зайтай харсан бол, хамгийн багадаа 4 км, хамгийн ихдээ 150 км зайд харсан байна. Мөн шонхор байгаа эсэхийг үүрээр ихэвчлэн таньдаг байна. Нийт шонхор харсан 41 оролцогчийн 82.9% нь шонхорыг таньж, тодорхойлж мэддэг бол, 17.1% нь таньж, тодорхойлж мэддэггүй байна.

Бүргэд. Судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 113 өрх буюу 75.3% нь бүргэдийг амьдаар харсан байна. Эдгээр 113 өрхийн 9.7% нь жилд нэг удаа, 35.4% нь заримдаа (2-12 удаа), 54.9% нь ойр ойрхон (жилд 13 ба түүнээс олон удаа) харсан байна. Бүргэд харсан иргэд сумын төвөөс дунджаар 28.9 км зайтай харсан бол, хамгийн багадаа 1 км, хамгийн ихдээ 80 км зайд харсан байна. Мөн бүргэд байгаа эсэхийг үүрээр ихэвчлэн таньдаг байна. Нийт бүргэд харсан 113 оролцогчийн 81.4% нь бүргэдийг таньж, тодорхойлж мэддэг бол, 18.6% нь таньж, тодорхойлж мэддэггүй байна.

Тарвага. Судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 120 өрх буюу 80% нь тарвага харсан ба үүнээс 79.3% нь амьдаар, 0.7% нь үхсэнээр харсан байна. Эдгээр 120 өрхийн 12.5% нь жилд нэг удаа, 39.2% нь заримдаа (2-12 удаа), 48.3% нь ойр ойрхон (жилд 13 ба түүнээс олон удаа) харсан байна. Тарвага харсан иргэд сумын төвөөс дунджаар 30.6 км зайтай харсан бол, хамгийн багадаа 1 км, хамгийн ихдээ 100 км зайд харсан байна. Мөн тарвага байгаа эсэхийг дошоор ихэвчлэн таньдаг байна. Тарвага харсан 120 оролцогчийн 89.2% нь тарвагыг таньж, тодорхойлж мэддэг бол, 10.8% нь таньж, тодорхойлж мэддэггүй байна.

Судалгаанд оролцогчдын 4.7% нь хулгайн ан агнуур нэмэгдсэн, 10.7% хэвэндээ, 45.3% багассан, 14% нь маш их багассан, 25.3% мэдэхгүй хэмээн үзсэн байна. Хулгайн ан агнуурыг хэн хийж байгааг тодруулахад 22% нутгийн иргэд, 22% сумын төвийн иргэд, 35.3% аймгийн төвийн иргэд, 22.7% Улаанбаатар хотынх, 46.7% мэдэхгүй хэмээн хариулсан байна.

Дүрс 18. Сүүлийн гурван жилд хулгайн ан буюу хууль бус ан агнуурт гарсан өөрчлөлт, n=150



Судалгаанд оролцогч талуудын үзэж буйгаар ан амьтдын тоо толгой төсөл хэрэгжсэнтэй холбоотой өссөн хэмээн үзэж байна. Ялангуяа буга, тарваганы тоо толгой мэдэгдэхүйц өссөн байна. Тухайлбал сүүлийн гурван жилийн хугацаанд тарваганы дош олширсон, буганы унасан эвэр харагдах болсон болон сүргээр бэлчээрлэх тохиолдол нэмэгдсэн байна. Энэхүү байгалийн ховордож буй амьтдын тоо толгой өсөж байгаа нь нөхөрлөлүүдийн хяналт сайжирсан, камержуулсан, хууль бус мод бэлтгэлийг зам давааг хаасан болон хууль дүрэм сайжирсантай холбон тайлбарлаж байна. Ховордож буй амьтдын тоо толгой өсөж буй шалтгааныг тайлбарлахдаа орон нутгийн удирдлага болон алба хаагчдын хувьд хулгайн ан багассан, хуулийн орчин сайжирсантай холбон тайлбарлаж байгаа бол нөхөрлөлийн ахлагчдын хувьд нөхөрлөлийн зохион байгуулалтад орж ойн хяналт сайжирсан, төслийн хүрээнд байгаль орчны мэдлэг олгох сургалт зохион байгуулсанаар иргэдийн мэдлэг, хандлага сайжирсантай холбон тайлбарлаж байна.

Шигтгээ 3.

... Нөхөрлөл байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлснээр иргэдийн байгаль орчин, зэрлэг амьтанд хандах хандлага маш их сайжирсан. Ан авыг дур зоргоороо хийхээ больсон.

(Сумын удирдлагатай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 4

... Тарваганы тоо манай суманд мэдэгдэхүйц өссөн. Өглөө эргүүл хийж дурандаж суухад ам болгонд 200-300 тарвага харагдаж байна. Өмнө нь тарваганы тоо толгой эрс багассан байсан нь хүмүүсийн хэрэглээ их байсантай холбоотой. Одоо тарваганы тоо толгой өсөж байгаа нь хуулийн орчин сайжирсан болон иргэдийн мэдлэг, хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотой...

(Байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 5

... Байгалийн зэрлэг амьтдын тоо толгой өсөж, ховор амьтад болох буга, хүдэр харагдах болсон. Энэ нь нөхөрлөлүүдийн байгаль хамгаалах үйл ажиллагаа болон идэвхтэн байгаль хамгаалагчдын үйл ажиллагаатай холбоотой. Цаашид идэвхтэн байгаль хамгаалагчдыг урамшуулах, цалин орлоготой болгосноор энэ үйл ажиллагаа илүү тогтворжих боломжтой...


(Идэвхтэн байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлагаас)

Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэлд дурдснаар Архангай амийн хэмжээнд сүүлийн жилүүдэд хуулийн орчин сайжирсантай холбоотойгоор ан амьтадын нөөц нэмэгдэх хандлагатай байгаа боловч хууль бус ан агнуур, мөн бэлчээрийн мал аж ахуйн бэлчээрийн давхцлаас шалтгаалж зарим ан амьтадын тоо толгой өсөхгүй байх хандлагатай байгааг тэмдэглэсэн байна.


Зорилт 2: Нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежмент

Ойн нөөц сүүлийн гурван жилийн хугацаанд хэр өөрчлөгдсөн эсэхийг тодруулахад 18.7% нь сайжирсан, 41.3% нь муудсан, 40% өөрчлөлт байхгүй хэмээн үзэж байна. Ойн нөөц багассан хэмээн үзэж байгаа 41.3% ойн нөөц доройтсон байдлын түвшинг тодорхойлохдоо 30.6% нь их, 50% нь дунд, 19.4% нь бага үзэж байна. Бэлчээр доройтсон хэмээн үзэж байгаа 41.3% бэлчээрийн доройтсон байдлын түвшинг тодорхойлохдоо 30.6% нь их, 50% нь дунд, 19.4% нь бага үзэж байна. Ойн нөөц сайжирсан гэж 28 оролцогч (18.7%) үзсэн ба нөхөрлөлийн гишүүнчлэлээр харьцуулан үзэхэд Баянбулаг 7, Бяцханчулуу 3, Могойхон 3, Тэххайрах 3, Жарантай 1, Наранбулаг 3, Өндөрхөтөл 1, Тэмээн чулууны 6 гишүүн сайжирсан гэсэн хариулт өгч байна.

Дүрс 19. Ойн нөөцийн нөхцөл байдал, n=150




Дүрс 20. Ойн нөөцийн доройтол, өсөлтийн түвшин, n=150



Суурь судалгааны шатанд өрхийн 64% нь сүүлийн 5-10 жилийн хугацаанд ой мод, баялаг доройтсон, 32% нь өөрчлөгдөөгүй, 4% нь ой болон бусад баялаг сайжирсан гэж үзсэн байна. Төсөл хэрэгжсэнээр ойн нөхцөл сайжирсан гэсэн харилт 14.7 функтээр өссөн, муудсан гэсэн хариулт 22.7 функтээр буурсан нь 3 жилийн хугацаанд гарсан маш сайн үзүүлэлт юм.


Дүрс 21. Ойн нөхцөл байдлын өөрчлөлт, суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт



Төсөл хэрэгжихээс өмнө ойн бүхэлдээ хямралд өртсөн байсан. Учир нь Архангай аймгийн Булган сумаас аймгийн төвийн иргэд түлшний мод бэлтгэж байсантай холбоотой юм. Харин төсөл хэрэгжсэний дараа нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулж зөвшөөрөлгүй замуудыг хаах, камержуулах, идэвхтэн байгаль хамгаалагчийн хяналттай холбоотой нөхцөл байдал маш их дээрдсэн талаар дурдаж байсан. Мөн нөхөрлөлд ойн цэвэрлэгээний зөвшөөрөл бүхий талбайг зааж өгсөнөөр нутгийн иргэдийн мод бэлтгэлийг хянах боломжтой болсон байна.

Орон нутагт хууль бус мод бэлтгэлийн талаар сүүлийн 12 сарын хугацаанд сонссон эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын 38% нь сонссон бол, 62% нь сонсоогүй байна. Харин хууль бус хулгайн мод бэлтгэлийн талаар сонссон оролцогчдын 45.6% нь 1-2 удаа мэдсэн, 7% нь 3-5 удаа мэдсэн, 15.8% нь 5-аас дээш удаа мэдсэн гэсэн хариултыг өгсөн бол үлдсэн хувь нь санахгүй, мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн. Судалгаанд оролцогчдын хэлж буйгаар модны хулгай мэдэгдэхүйц багассан гэсэн хариултыг өгч байсан.

Дүрс 22. Хууль бус мод бэлтгэлийн талаар сонссон эсэх, n=150




Дүрс 23. Сүүлийн 12 сард хэдэн удаа хууль бус мод бэлтгэлийн хэрэг гарсан, n=150




Суурь судалгааны шатанд нийт өрхийн 80% нь ОНТХГ-т гарсан хууль бус мод бэлтгэлийн талаар сонсож, харж байгаагүй бол 20% нь энэ талаар мэдээлэл авч байжээ. Өөрчлөлтийг авч хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлэл авсан иргэдийн хувь 18 функтээр өссөн нь иргэдийн хяналт эргүүл тогтолцоо сайжирсантай холбоотой байна.

Дүрс 24. Хууль бус мод бэлтгэлийн талаар сонсож байсан эсэх, суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт




Сүүлийн гурван жилийн хугацаанд хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийг үзэхэд 8.7% нь нэмэгдсэн, 14.7% нь хэвэндээ, 63.4% багассан гэсэн бол 13.3% мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. Хэн хууль бусаар бэлтгэж байгааг тодруулахад 20.7% нь нутгийн иргэд, 26.7% нь сумын төвийн иргэд, 45.3% нь аймгийн төвийн иргэд, 6.7% нь Улаанбаатарынх, 34% мэдэхгүй хэмээн хариулсан байна.

Дүрс 25. Сүүлийн гурван жилийн хугацаанд зөвшөөрөлгүй мод бэлтгэлд гарсан өөрчлөлт, n=150



Нөхөрлөлийн гишүүдээс бүрдсэн ойн эргүүлийн идэвхтэн баг байгуулагдсан эсэхийг судалгаанд оролцсон нөхөрлөлийн гишүүдээс тодруулахад 90.7% нь байгуулагдсан гэсэн бол, үлдсэн 9.3% нь байгуулагдаагүй гэсэн хариултыг өгсөн. Хэрэв тийм бол ойн эргүүлийн идэвхтэн баг сард хэдэн удаа эргүүл хийж байгааг тодруулахад дунджаар 18.4 удаа, хамгийн багадаа нэг, хамгийн ихдээ 99 удаа гэсэн байна.

Дүрс 26. Эргүүлийн идэвхтэн баг байгуулагдсан эсэх, n=150



Хүснэгт 9. Сард хийсэн эргүүлийн идэвхтэн багийн эргүүлийн тоо,

Хамгийн их утга	99
Хамгийн бага утга	1
Дундаж утга	18.4
Медиан	3
Хамгийн их давтагдсан утга	3

Сумын хэмжээнд байгалийн дагалдах баялаг хууль бусаар ашигласан хэрэг зөрчил 2019 онд 36 бол, 2020 онд идэвхтэн байгаль хамгаалагч болон иргэдийн мэдээлэлд үндэслэсэн 18 хэрэг илрүүлж шийдсэн байна. Дээрх тооноос үзвэл жилийн хугацаанд хууль бус хэрэг зөрчил хоёр дахин буурсан байна.

Ярилцлагад хамрагдсан талуудын үзэж буйгаар орон нутгийн иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтад орсноор ой мод цэвэрлэх, нөхөн сэргээх эрхтэй болсноор түлшний мод бэлтгэх боломжтой болсон. Ингэснээр заагдсан талбайд ойн цэвэрлэгээ хийх замаар түлшний мод бэлтгэх болон самар, жимснээс орлого олох боломж бүрдсэн байна. Орон нутгийн удирдлага болон албан хаагчдын хувьд орон нутгийн иргэд нөхөрлөл байгуулснаар байгалийн баялгийг зүй зохистой хуулийн дагуу ашиглах боломж бүрдсэн хэмээн дүгнэсэн ба цаашид нөхөрлөлүүд үйл ажиллагаа өргөжүүлж, хоршооны хэлбэрээр ажиллаж ашиг орлого олох боломжтой хэмээн үзэж байна. Нөхөрлөлийн ахлагчдын хэлж буйгаар ойн цэвэрлэгээг зөвшөөрөгдсөн талбайгаас хийснээр түлш мод бэлтгэн орлогоо нэмэгдүүлэх боломж бүрдсэн талаар дурдсан. Нөхөрлөлийн өрх толгойлсон иргэнээс байгалийн баялаг буюу ойн нөөцийг ашиглаж байгаа нөхцөлийг тодруулахад ойн цэвэрлэгээнээс орлого олохын зэрэгцээ, нөхөн сэргээлт хийж байгаадаа сэтгэл ханамжтай байна гэсэн бол байгаль хамгаалагчид болон идэвхтэн байгаль хамгаалагчдын хувьд мод бэлтгэх болон ойн цэвэрлэгээ хийх ажил хууль дүрмийн дагуу явагдаж байгаад сэтгэл ханамж өндөртэй байлаа. Ярилцлагад хамрагдсан талууд бүгд сүүлийн гурван жилийн хугацаанд ойн нөхцөл байдал маш их сайжирсан буюу тав гэсэн үнэлгээг өгсөн.

Байгалийн баялгаас орон нутагт төвлөрсөн орлогыг сүүлийн хоёр жилээр авч үзэхэд төдийлөн өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 10. Байгалийн баялагаас орон нутагт төвлөрсөн орлого, мөнгөн дүнгээр

№	Байгалийн баялагаас олсон орлогын төрөл	2018	2019
1	Ой мод	30,099,250	31,316,336
2	Ан амьтан	280,000	420,000

Мөн орон нутгийн иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтад орсноор мэргэжлийн байгууллагын туслан гүйцэтгэгчээр ажиллах боломж бүрдсэн ба мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдсэн.

Шигтгээ 6.

...Нөхөрлөлийн хувьд ойн цэвэрлэгээ, самар түүх ажлуудыг улирлын чанартай хийж гүйцэтгэдэг. Өнгөрсөн намрын тухайд самар сайн ургасантай холбоотойгоор нөхөрлөлийн гишүүн өрхүүд орлого сайн олсон...

(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 7

...Хулгайгаар мод бэлтгэх явдал одоо 100% байхгүй болсон. Иргэдийн хувьд нөхөрлөл бий болсноор идэвхтэн байгаль хамгаалагч, гишүүд байнгын сонор сэрэмжтэй байж, тогтмол эргүүл хийдэг болсон. Аймаг, сумын төвөөс ирж байгаа иргэдийн бичиг баримтыг шалгаж байж ой мод руу оруулдаг. Орон нутгийн иргэдийн хувьд 100% модноос орлогын эх үүсвэрээ хангаж байгаа өрх байхгүй. Орон нутгийн иргэд мод бэлтгэх шаардлагатай үед нөхөрлөлөөр дамжуулаад сумаас зөвшөөрөл аваад, мод бэлтгэх газраа заалгаад зохион байгуулалттай авдаг...

(Идэвхтэн байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 8

...Байгаль орчны газраас чиглэл өгсөний дагуу манай багийн хоёр нөхөрлөлийн хувьд ойн цэвэрлэгээний ажлыг нэгдсэн журмаар хавар, намар хийдэг. Түүнд манай багийн иргэд хамрагдаж ойн хаягдал, хугарсан модыг зөвшөөрөлтэйгээр тээвэрлэж, бага үнээр аймгийн иргэдэд борлуулдаг. Сүүлийн хоёр жилд хавар, намартай нийт дөрвөн удаа зохион байгуулсан. Мөн өнгөрсөн намар самар их ургасантай холбоотой иргэд самарнаас орлого олсон. Олсон орлогоороо малчны зээл, оюутны сургалтын төлбөрөө төлж байсан.

(Багийн удирдлагатай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 9

...Нөхөрлөлийн гишүүдийн хувьд сүүлийн хоёр жил гаруй ойн цэвэрлэгээнд оролцож байна. Мод тарих, тарьсан модыг хамгаалах чиглэлээр нөхөрлөлүүд хамтарч ажиллаж байна. Цэвэрлэгээнд оролцсоноор нэг хүн өдрийн 200,000-300,000 төгрөгийн орлоготой байдаг....

(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)

Орон нутгийн иргэдийн хувьд хуулийн дагуу ойн нөөцийг ашиглаж, нөхөн сэргээх боломжтой ба цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд олон чиглэлийн ажил хийх сонирхолтой байна. Байгалийн нөөцөө зүй зохистой ашиглахын зэрэгцээ нөхөн сэргээх үйл ажиллагааг илүү чанартай хийж, байгальтай зүй зохистой харилцах аргад суралцах нь цаашдын үйл ажиллагаанд чухал нөлөөтэй.

Зорилт 3: Бэлчээрийн тогтвортой менежмент бүхий ОНТХГ

Бэлчээрийн нөхцөл байдал сүүлийн 3 жилийн хугацаанд хэр өөрчлөгдсөн эсэхийг тодруулахад 6.7% нь сайжирсан, 73.3% нь муудсан буюу доройтсон, 20% нь өөрчлөлт байхгүй хэмээн үзэж байна. Бэлчээр доройтсон хэмээн үзэж байгаа оролцогчдын 73.3% нь бэлчээрийн доройтсон байдлын түвшинг тодорхойлохдоо 43.6% нь их, 41.8% нь дунд, 14.5% нь бага үзэж байна. Бэлчээрийн нөхцөл сайжирсан гэж 10 оролцогч (6.7%) үзсэн ба нөхөрлөлийн гишүүнчлэлээр харьцуулан үзэхэд Баянбулаг 2, Могойхон 2, Тэх харайх 1, Жарантай 1, Наранбулаг 1, Өндөр хөтөл 1, Тэмээн чулуут 1, Баянханчулууны 1 гишүүн сайжирсан гэсэн хариулт өгч байна.

Дүрс 27. Бэлчээрийн нөхцөл байдал, n=150



■ Сайжирсан ■ Муудсан ■ Өөрчлөлт байхгүй


Дүрс 28. Бэлчээрийн доройтсон байдлын түвшин



■ Их ■ Дунд ■ Бага

Суурь судалгааны шатанд өрхүүдийн 73% нь сүүлийн 5-10 жилийн хугацаанд бэлчээрийн нөхцөл байдал доройтсон, 11% нь өөрчлөгдөөгүй, 7% бэлчээрийн нөхцөл байдал сайжирсан гэж үнэлсэн байна. Доорх харьцуулсан үзүүлэлтээс харахад сүүлийн гурван жилийн хугацаанд бэлчээрийн нөхцөл байдалд өөрчлөлт гараагүй байна.

Дүрс 29. Бэлчээрийн нөхцөл байдал, n=150, Суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт




■ Суурь судалгаа ■ Төгсгөлийн судалгаа

Бэлчээрийн нөхцөл муудаж байгаа шалтгааныг малчид тайлбарлахдаа голлон малын тооны өсөлттэй холбон тайлбарлаж байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд байгалийн баялагийг нөхөн сэргээх байдалд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад 31.3% нь сайжирсан, 12.7% нь муудсан, 56% нь өөрчлөлт байхгүй гэсэн байна. Судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 47 буюу 31.3% нь байгалийн баялгийг нөхөн сэргээх байдал дээшилсэн гэж үзсэн ба түүнээс 10.64% нь их сайжирсан, 85.1% дунд, 4.3% нь бага зэрэг хэмээн хариулсан.

Дүрс 30. Байгалийн нөөцийг нөхөн сэргээх нөхцөл байдал, n=150




Дүрс 31. Байгалийн нөөцийг нөхөн сэргээх байдлын бүүралт, өсөлтийн түвшин, n=150



Байгалийн нөөц болон бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр явуулсан үйл ажиллагааг тодруулахад 68% нь булаг, шанд, хадлан болон өвөлжөө, хаваржааны талбай хашаалсан бол, 43.3% нь бэлчээр сэлгэн нүүдэллэх, 18% нь малын тоо, толгойг бууруулах, 12.7% нь зэрлэг амьтны бэлчээрээс холуур нүүдэллэх, 12% нь бэлчээр сонгож нөхөн сэргээлтийн туршилт хийх ажлуудыг зохион байгуулсан байна.

Дүрс 32. Байгалийн нөөц болон бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр явуулсан үйл ажиллагаа, n=150



Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын үзэж буйгаар сүүлийн гурван жилийн хугацаанд бэлчээрийн нөхцөл байдал улам муудаж байгааг тэмдэглэж байна. Бэлчээрийн нөхцөл байдал муудаж байгаа шалтгааныг малын тооны өсөлт болон байгаль цаг уурын өөрчлөлттэй холбон тайлбарлаж байна. Орон нутгийн иргэдийн хувьд бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор бэлчээр сэлгэн нүүдэллэх, хадлангийн талбай хашаалах, өвөлжөө газраа намар, хавартаа нутаглах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

Орон нутгийн удирдлагын зүгээс бэлчээрийн нөхцөл байдлыг дээшлүүлэхийн тулд малын чанарыг сайжруулах, малын тоог багасгах, өөр сумаас ирж нутаглаж байгаа отрын малчдыг багасгах болон онцгойлон аймгийн төвийн харъяалалтай малчдыг багасгавал бэлчээрийн нөхцөл байдал өөрчлөгдөх, боломж байгааг талууд онцолж байна.

Нөхөрлөлийн ахлагчдын хувьд өөрт сум, орон нутгаас ирж оторлож байгаа малчид хязгаарлах болон нөхөрлөлийн малчид нэгдсэн журмаар бэлчээр сэлгэн нүүдэллэх тал дээр анхаарч байна.

Нөхөрлөлийн гишүүдийн хувьд тухайн газар нутаглаж байгаа малчид бүгд нэгэн зэрэг нутаг сэлгэн нүүдэллэх хэрэгцээ, шаардлага байгааг онцолж байсан. Одоогийн байдлаар зарим өрхүүд нь бэлчээр

сэлгэн нүүдэл хийж байгаа бол зарим өрхүүд нь бэлчээр сэлгэн нүүдэл хийхгүй байгаагаас хамааран төдийлөн үр дүн гарахгүй байна.

Шигтгээ 10
...Малчдын бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг дутмаг байна. Мөн отрын малчид дураараа ирсэнтэй холбоотойгоор бэлчээрийн даац маш их буюу 10-15 хувиар хэтэрсэн байна...
(Нөхөрлөлүүдийн холбооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас)
Шигтгээ 11
...Малын тоо толгой өссөнөөр бэлчээргүй болсон. Мал ихдээд өвс ногоо ургахгүй, гол улс ширгэж байна. Нөхөрлөл байгуулснаар бэлчээрээ сэлгэж, отор нүүдэл хийж, хадлангийн талбайгаа хашаалах ажлуудыг хийж байна.
(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)
Шигтгээ 12
...Нөхөрлөлийн гишүүдийн хувьд бэлчээрийн даац, өвс ургамалын гарц муудаж байгаа талаар ойлголцотой болсон. Өмнө нь тухайн газарт гурван айл байхад хоёр нь бэлчээр сэлгээд нүүдэг байсан учраас бэлчээр сэлгэлт үр дүнгүй болдог байсан. Энэ жилийн тухайд бүгд бэлчээр сэлгэж нүүсэн. Энэ зун хойд Тамираа давж отор хийсэн...
(Өрх толгойлсон эрэгтэйчүүдийн төлөөлөл, нөхөрлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагаас)
Шигтгээ 13
... Манай эндхийн бэлчээр маш муудсан. Сүүлийн жилүүдэд өвс, ургамал ургахаа байсан. Малын тоо толгой тогтмол өсөж байна...
(Идэвхтэн байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлагаас)
Шигтгээ 14
...Малчид малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй байна. Малын тоо толгойгоо багасгаж эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломж байна. Олон үнээ сагаад 10,20 литр сүү авсан дээр үү? эсвэл 2-3 үнээ сагаад 10,20 литр сүү авах уу? гэдгээ сайн бодох хэрэгтэй байна. Цөөн үнээнээс их сүү авбал эдийн засгийн хувьд ч хэмнэлттэй...
(Идэвхтэн байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлагаас)

Оролцогч талуудын саналаар орон нутагт бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах оновчтой менежментийн бодлого хэрэгтэй, мөн малчид бэлчээрээ тогтмол сэлгэн нүүдэллэх болон ойрын хугацаанд бэлчээрийн даац хэирэлтийг багасгах шаардлага байгааг онцолж байна.

Зорилт 4: Орлогын олон талт эх үүсвэр бүхий нөхөрлөл, иргэд


Сүүлийн гурван жилийн хугацаанд байгалийн нөөц баялгаас орлого олох нөхцөл хэр өөрчлөгдсөнийг тодруулахад 21.3% нь сайжирсан, 13.3% нь муудсан, 65.3% өөрчлөлт байхгүй хэмээн үзэж байна. Байгалийн нөөц, баялгаас орлого олох боломж буурсан хэмээн үзэж байгаа 13.3% нь тодорхойлохдоо 25% нь их, 50% нь дунд, 14.3% нь бага гэж үзэж байна.

Дүрс 33. Сүүлийн гурван жилийн хугацаанд байгалийн нөөц баялгаас орлого олох нөхцөл байдал, n=150



■ Сайжирсан ■ Муудсан ■ Өөрчлөлт байхгүй


Дүрс 34. Сүүлийн гурван жилийн хугацаанд байгалийн нөөц баялгаас орлого олох боломжийн түвшин, n=150



■ Их ■ Дунд ■ Бага


Өрхүүдийг төслийн үйл ажиллагаанаас хүрээнд нэмэлт орлого олж байгааг тодруулахад 52.7% нь хуримтлалын бүлэг үүсгэх, 42% цагаан идээ боловсруулах, 10.7% нь эко аялал жуулчлал гэсэн хариултыг түлхүү өгч байна.

Дүрс 35. Төслийн үйл ажиллагаанд оролцож орлогоо нэмэгдүүлсэн хэлбэр,



Судалгаанд оролцогчдын хувьд байгалийн нөөцөд суурилсан баялаг болох зэрлэг амьтан, мод, жимс жимсгэнээс орлого олсон эсэхийг тодруулахад нийт 150 өрхөөс нэг өрх зэрлэг амьтнаас, 40 өрх модноос, 43 өрх жимс жимсгэнээс орлого олсон байна.

Дүрс 36. Байгалийн нөөц баялгаас орлого олсон байдал, n=150



Оролцогч талуудын үзэж буйгаар нөхөрлөлд хамрагдсан өрхүүдийн орлогын олон талт байдал нэмэгдсэн байна. Орлого нэмэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь ойн цэвэрлэгээний орлоготой

холбоотой байна. Төслийн зүгээс өрхийн орлогын олон талт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ойн цэвэрлэгээ хийх тоног төхөөрөмж болон нөхөрлөлийн дундын санг бий болгох, аж ахуй эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн үр дүнтэй болсон байна.

Нөхөрлөлийн ахлагчдын хувьд төслийн зүгээс өгсөн тоног төхөөрөмжөөр цагаан идээ боловсруулах, газар тариалан эрхлэх гэх мэт үйл ажиллагааг явуулах болсон ба дундын хуримтлал бий болгосноор өрхийн амьжиргаанд ч нөлөөлж байна.

Нөхөрлөлийн гишүүдийн хувьд ойн цэвэрлэгээ болон цагаан идээ үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн тусламжтайгаар орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлж байна.

Төрийн албан хаагчдын зүгээс цагаан идээ, модны чиглэл, болон блок цохих болон ойн цэвэрлэгээ хийх гэх мэтээр бүх нөхөрлөлүүд тодорхой хэмжээний орлогын олон талт эх үүсвэртэй болсон гэж дүгнэжээ.

Хүснэгт 11. Нөхөрлөлүүдийн орлогын олон талт байдал, 1-5 оноогоор

№		Ерөнхий	Ой мод	Цагаан идээ	Аялал жуучлал	Ноос ноолуур
1	Орон нутгийн удирдлага	4,8	5	4	1	-
2	Идэвхитэн байгаль хамгаалагчид ба байгаль хамгаалагчид	-	-	-	1	-
3	Өрх толгойлсон иргэд	5	5	5	1	-
4	Нөхөрлөлийн ахлагчид	5	5	3	-	-

Орон нутгийн удирдлагууд төслийн зүгээс явуулсан үйл ажиллагааг “маш сайн” үр дүнтэй байсан хэмээн үнэлж байна. Эдгээрээс нөхөрлөлийн гишүүдийн орлогыг нэмэгдүүлэхэд ойн цэвэрлэгээ ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн цагаан идээ боловсруулах үйл ажиллагаа нь тоног төхөөрөмжийн дэмжлэгийн үр дүнд сайжирсан ба үзэсгэлэн худалдаанд оролцох болсноороо борлуулалт сайжирсан гэж үзжээ. Аялал жуучлалын үйл ажиллагаа эрхлэх тал дээр нөхөрлөлүүдэд тодорхой дэмжлэгийг үзүүлсэн боловч COVID-19 цар тахал гарсантай холбоотойгоор хараахан үйл ажиллагаа нь амжилттай явагдаагүй байна.

Шигтгээ 15

...Бүх нөхөрлөлийн хамтарсан 50-80 гишүүний бүрэлдэхүүнтэй 3-4 удаа ойн цэвэрлэгээ хийсэн. Орлогын хувьд дунджаар авч үзэхэд нэг цэвэрлэгээнээс нэг өрх 800,000-1,000,000 төгрөг олсон. Нөхөрлөлүүд энэ олсон зардлаа ойр зуурын хэрэгцээ болон дундын сандаа хуримтлал үүсгэх чиглэлд зарцуулж байна...

(Нөхөрлөлүүдийн холбооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 16

...Төслийн зүгээс цагаан идээний тоног төхөөрөмжүүд олгосон. Тоног төхөөрөмж ашиглан хийсэн ааруул, цагаан идээ 100% борлуулсан. Манай нөхөрлөлийн гишүүд хамтран цагаан идээ боловсруулан үзэсгэлэн худалдаанд оролцож байна. Мөн өмнө нь цагаан идээ хувиараа боловсруулж борлуулдаг байсан иргэдийн хувьд одоо цагаан идээг улам өргөн борлуулж байна...

(Өрх толгойлсон эрэгтэйчүүдийн төлөөлөл, нөхөрлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 17

...Ойн цэвэрлэгээг нөхөрлөлийн шугамаар дамжуулан хийж байгаа. Ойн цэвэрлэгээнээс олсон мөнгөнөөс бензин аваад, үлдсэн мөнгөө дундаа сандаа хийдэг...

(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 18

...Манай багийн нэг нөхөрлөл блокны машин аваад өөрсдөө блок цохиод илүү гарсан блокоо зарж борлуулаад ашиг олсон. Сүүлийн нэг жил энэ ажил зогссон. Нөхөрлөл иргэдийн амьдралд маш их нөлөөлсөн. Иргэд байгаль орчны талаар маш их ойлголт мэдээлэлтэй болсон...

(Багийн засаг даргатай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 19

...Төслөөс цагаан идээний тоног төхөөрөмж авсан. Бөөрөнхий ааруул хэвлэдэг машинаа сайн ашиглаж чадахгүй байгаа. Сүүгээ машиндаад цөцгий авч байгаа. Бөөрөнхий ааруул хэвлэх машиныг хэрхэн ашиглах талаар сургалт ороогүй байгаа...

(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 20

...Ирэх зунаас жуулчин авч ажиллах байх. Энэ жил COVID-19 цар тахлаас хамааран жуулчин авч чадаагүй..


(Өрх толгойлсон эрэгтэйчүүдийн төлөөлөл, нөхөрлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагаас)

Нөхөрлөлийн гишүүдийн хувьд хамтарч цагаан идээгээ боловсруулах, ойн цэвэрлэгээ хийх, самар түүж борлуулах, газар тариалан эрхлэх, дундын санд хуримтлалтай болох гэх мэт үйл ажиллагаагаар дамжуулан өрхийн эдийн засгийн байдлаа сайжруулах боломжтой болжээ. Төслийн зүгээс тоног төхөөрөмжөөр хангах болон шаардлагатай арга зүйн сургалтуудыг зохион байгуулах ажлыг түгээмэл хийсэн ба COVID-19 буюу цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан аялал жуучлал эрхлэх үйл ажиллагаа болон зарим сургалт, хөгжлийн үйл ажиллагаанууд саатсан байна. Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд орон нутгийн удирдах байгууллагууд болон нөхөрлөлийн хамтын ажиллагааг сайжруулж, бусад оролцогч талуудыг идэвхжүүлэх шаардлагатай байгаа юм.

Зорилт 5: ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэх


Судалгаанд хамрагдсан оролцогчдын 94.7% нь Байгалийн нөөцийн хамтын менежментийн (БНХМ)-ийн нөхөрлөлийн гишүүд байна. Энэхүү Архангай аймгийн Булган сумын Могойн гол орчмыг ОНТХГ газар болгосон талаар нутгийн иргэд, нөхөрлөлийн гишүүдийн 83.3% нь мэдэж байна. ОНТХГ-ын удирдлага/ менежментийн уулзалтад судалгаанд оролцогчдын 42.4% нь хамрагдсан байна.

Дүрс 37. ОНТХГ-ын мэдээлэл, %




Суурь судалгааны шатанд жилд нийт 150 өрхийн есөн гишүүн буюу 6% нь байгаль хамгаалах санаачилгад нэгдэж байсан бол төгсгөлийн үнэлгээгээр 150 өрхийн 72 гишүүн буюу 48% байгаль хамгаалах санаачилгад нэгдсэн байна. Хойд Могойн гол, Тээл орчмын бүс нутгийг ОНТХГ-т авсан гэдгийг суурь судалгааны шатанд нутгийн иргэдийн 46% мэдэж байсан бол, төгсгөлийн шатанд 83.3% болж нэмэгдсэн байна.

Дүрс 38. Сүүлийн 12 сарын байгаль хамгаалах санаачилгад хамрагдсан эсэх. %




Дүрс 39. ОНТХГ-т авсан гэдгийг мэдэх эсэх, %
Суурь болон төгсгөлийн судалгааны харьцуулалт



Төсөлд хамрагдсан нөхөрлөлийн гишүүдийн хувьд байгаль хамгаалал, экосистемийн биологийн олон янз байдлын мониторинг төлөвлөгөө боловсруулах ажилд 25.3% нь оролцсон бол, мониторинг хийх үйл ажиллагаанд 3.3% нь хамрагдсан байна. Харин байгаль хамгааллын чиглэлийн сургалт, уулзалтад 56.7% нь хамрагдсан байна.

Дүрс 40. Байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд сүүлийн гурван жилийн хугацаанд оролцсон байдал, %



Иргэдийн хувьд байгаль хамгааллын сургалт, уулзалтад сүүлийн гурван жилийн хугацаанд дунджаар 4.2 удаа, хамгийн багадаа нэг, хамгийн ихдээ 30 удаа хамрагдсан байна. Харин байгаль хамгаалал, экосистемийн биологийн олон янз байдалд мониторинг хийх төлөвлөгөө боловсруулах ажилд дунджаар 4.2 удаа оролцсон бол төлөвлөгөөний дагуу мониторинг хийх ажилд дунджаар 2.5 удаа оролцсон байна. Байгаль хамгааллын сургалт, үйл ажиллагаанд оролцсон байдлыг хүйсээр харьцуулан үзвэл төдийлөн ялгаа байхгүй байна.

Хүснэгт 12. Байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон байдал, тоо

№	Утга	Байгаль хамгааллын сургалт, уулзалтад оролцсон эсэх	Байгаль хамгаалал, экосистемийн биологийн олон янз байдалд мониторинг төлөвлөгөө боловсруулсан эсэх	Байгаль хамгаалал, экосистемийн биологийн олон янз байдалд мониторинг хийх үйл ажиллагаанд оролцсон эсэх
1	Хамгийн их утга	30	36	10
2	Хамгийн бага утга	1	1	1
3	Дундаж утга	4.2	4.2	2.5
4	Медиан	3	3	2
5	Хамгийн их давтагдсан утга	2	2	2

Ярилцлагад хамрагдсан талуудын хувьд ОНТХГ-ын хамтын нөхөрлөлийн менежментийг бий болгох хүрээнд “маш сайн” үр дүнтэй байсан хэмээн үнэлж байна. ОНТХГ-т хамтын нөхөрлөлийн менежментийг бий болгосноороо өмнөхөөсөө илүү эерэг өөрчлөлтүүд гарч байна.

Орон нутгийн удирдлага болон албан хаагчдын ОНТХГ-ын менежментийг цаашид улам сайжруулахын тулд идэвхтэн байгаль хамгаалагчдыг тогтмол урамшуулдаг байх хэрэгтэй байна. Мөн байгалийн нөөц баялгаас олсон орлогыг орон нутагт төвлөрүүлдэг байх нь чухал юм. Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээр сэлгэн нүүдлэх үйл ажиллагааны хяналтыг сайжруулахын тулд сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагчийг авч үлдэх шаардлагатай байна.

Нөхөрлөлийн ахлагчдын хувьд орон нутгийн иргэд хамтын зохион байгуулалтад орсон, байгаль орчноо хамгаалах, сургалт сурталчилгаанд хамрагдсан, дундын сангийн бий болгосон зэргийг эерэгээр үнэлсэн.

Нөхөрлөлийн гишүүдийн хувьд хамтын ажиллагаа бий болгосон, маш сайн менежмент хийсэн ба хамтын ажиллагаанаас үүдэн малчдын дунд маргаан, зөрөлдөөн байхгүй болсон зэргийг эерэгээр үнэлсэн байна.

Идэвхтэн байгаль хамгаалагчдын хувьд сүүлийн гурван жилийн хугацаанд сургалт семинарт хамрагдсанаараа байгаль орчноо хамгаалах талаар ойлголттой болсон. Цаашид идэвхтэн байгаль хамгаалагчдыг урамшуулах, санхүүгийн (цалин хөлс, бензиний зардал) тал дээр дэмжлэг үзүүлж одоогийн хамтын зохион байгуулалтыг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 13. Оролцогч талуудын ОНТХГ-ын менежментийн тогтолцоог үнэлсэн байдал, 1-5

	Төрийн албан хаагчид	Нөхөрлөлийн ахлагчид	Нөхөрлөлийн гишүүн	Байгаль хамгаалагчид болон ИБХ
ОНТХГ-ын менежментийн тогтолцоо	4	5	4	3

*1 бол маш муу, 2 бол муу, 3 дунд зэрэг, 4 бол сайн, 5 бол маш сайн)

Ярилцлагад хамрагдсан талуудын хувьд ОНТХГ-ын менежментийн тогтолцоог ерөнхийдөө дөрөв буюу сайн хэмээн үнэлж байна.

Шигтгээ 21

Нөхөрлөлүүд болон орон нутгийн хамтын ажиллагааны тал дээр тааруухан байдаг. Яриад л өнгөрдөг боловч аливаа зүйлийг хэрэгжүүлэх тал дээр маш муу.

(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 22


...Уг нь төрийн байгууллагуудтай хамтарч ажиллахгүй бол бид нар дангаараа дур мэдэж юм хийхэд хэт төвөгтэй. Жишээ нь гоожин авахын тулд заавал төрийн байгууллагатай хамтарч ажиллаж байж түүнийгээ яг зөв чиглэлээр гаргуулж авч чадна гэсэн үг. Төрийн байгууллагаас жилд ойгоос 40 гаруй сая төгрөг олдог гэсэн. Гэхдээ тэр мөнгийг нь аймгийн татварын газраас хурааж авдаг. Ганц ойн цагдааг л цалинжуулдаг. Түүнээсээ ядаж хоёр ойн идэвхитэн хамгаалагчдаа цалин олгодог бол сайн байна. Мөн тухайн орон нутгаас олсон орлогоо тухайн газар нутагт нь зарцуулдаг баймаар байна...

(Нөхөрлөлийн ахлагчтай хийсэн ярилцлагаас)

Шигтгээ 23

...Ерөнхийдөө энэхүү сургалт үйл ажиллагааны үр дүнд малчид маань эвлэлдэн нэгдэж ойн түймэр, байгалиа нөхөн сэргээх гэх мэт үйл ажиллагааг хийж байна. Төсөл дуусахад нөхөрлөлүүд дундын сангаа үргэлжлүүлэх байдал бий болсон байгаа...

(Нөхөрлөлийн холбооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас)



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ИРГЭДИЙН
ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ
АСУУДАЛД ТӨСЛӨӨС ҮР ШИМ
ХҮРТЭГЧДИЙН ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ**

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АСУУДАЛД ТӨСЛӨӨС ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ХАНДАХ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ


Төсөл хэрэгжсэнээр Архангай аймгийн Булган сумын иргэд байгаль орчин, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, биологийн олон янз байдлын талаар ямар үзэл бодол, хандлагатай болсныг тандан судалж, энэ хэсэгт шинжилгээний үр дүнг тайлагнав. Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамааруулан төслийн үндсэн таван үйл ажиллагаа тус бүрээр шинжилгээний үр дүнг нэгтгэлээ.

Ховордож буй зэрлэг амьтны хамгаалал, мониторинг бий болгох талаар иргэдийн хандлага

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төслийн хүрээнд 11 нөхөрлөл байгуулснаас 10 нөхөрлөл 272 гишүүнтэйгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Нөхөрлөл бүр идэвхтэн байгаль хамгаалагчтай, тарваганы цэгэн тооллогын судалгаа, хүдрийн байршил тодорхойлох камер тавих судалгаа, шувууны зүйлийн бүрдэл судалгаа, идэвхтэн байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулж, биологийн олон янз байдлын судалгааг хийн, зэрлэг амьтныг хамгаалах SMART мониторингийн аргыг нэвтрүүлжээ. Нөхөрлөл байгуулснаар зэрлэг амьтны хууль бус агнуурын зөрчил гарах байдал буурч, тарвага, талын бүргэд, шонхор, хүдрийн төрөл зүйл бүр 50 орчим хувиар өссөн байна.

Ховордож буй зэрлэг, амьтны хамгаалал, мониторинг бий болгох чиглэлд хийсэн эдгээр үйл ажиллагаанд оролцсон, төслийн үр шимийг хүртэгч 150 өрхийн 65.3% (Дүрс 41) нь ан ав хийхийг ямар нэгэн байдлаар хориглох нь маш их ач холбогдолтой гэж үнэлжээ. Түүнчлэн тэдний 18.0% нь ан ав хийхийг хориглох нь ерөнхийдөө ач холбогдолтой гэж үзсэн бол 14.0% нь ач холбогдлын түвшин дундаж гэж үзжээ. Ан ав хийхийг хориглохын ач холбогдлыг үнэлсэн үнэлгээнд нас, хүйс, боловсролын ялгаа байгаа эсэхийг вариацийн шинжилгээгээр шинжлэхэд 95%-ын итгэх завсарт эдгээр ялгаа байхгүй нь тогтоогдсон юм. Харин нөхөрлөлийн гишүүд ан ав хийхийг хориглох байдалд ач холбогдол өгөх магадлал буурч байна. ($F = 1.69$, $P - value = 0.196$)

Дүрс 41. Ан ав хийхийг хориглох байдал, n=150



Дүрс 42. Ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх байдал, n=150



Дэлхийд ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх ажлыг дэмжих нь маш их ач холбогдолтой гэж судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 84 өрх буюу 56.0%, ерөнхийдөө ач холбогдолтой гэж 20.7%, дундаж ач холбогдолтой гэж 22.0%, ач холбогдол бага гэж 1.3% үнэлжээ. (Дүрс 42) Үнэлгээний үр дүн судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой зөрүүгүй байв.

Суурь судалгааны шатанд жилд нийт 150 өрхийн есөн гишүүн буюу 6% нь байгаль хамгаалах санаачилгад нэгдэж байсан бол төгсгөлийн үнэлгээгээр 150 өрхийн 72 гишүүн буюу 48% байгаль хамгаалах санаачилгад нэгдсэн байна. Хойд Могойн гол, Тээл орчмын бүс нутгийг ОНТХГ-т авсан гэдгийг суурь судалгааны шатанд нутгийн иргэдийн 46% мэдэж байсан бол, төгсгөлийн шатанд 83.3% болж нэмэгдсэн байна.

Дээрх шинжилгээний үр дүнгээс дүгнэхэд төслийн үр шим хүртэгчдийн дийлэнх олонх нь ан ав хийхийг ямар нэгэн байдлаар зохицуулах, дэлхийн ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх ажлыг дэмжих хэрэгтэй гэж үзжээ.

Дэлхийд ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх ажлыг дэмжих нь маш их ач холбогдолтой гэж судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 84 өрх буюу 56.0%, ерөнхийдөө ач холбогдолтой гэж 20.7%, дундаж ач холбогдолтой гэж 22.0%, ач холбогдол бага гэж 1.3% үнэлжээ (Дүрс 42). Үнэлгээний үр дүн судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой зөрүүгүй байв.


Дээрх шинжилгээний үр дүнгээс дүгнэхэд **төслийн үр шим хүртэгчдийн олонх нь ан ав хийхийг ямар нэгэн байдлаар зохицуулах, дэлхийн ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх ажлыг дэмжих хэрэгтэй** гэж үзжээ.

Нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох талаар иргэдийн хандлага


Төслийн хүрээнд нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох чиглэлд орон нутгийн иргэд, малчдыг байгалийн нөөцийн хамтын нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулалтад оруулж, нөөцийг зохистой ашиглах менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн байна. Энэ хүрээнд ойн цэвэрлэгээ хийж, байгалийн нөхөн ургалтад туслах ажил гүйцэтгэн, ойн болон голын эргийн бүсийг хортон, түймрээс хамгаалах байнгын эргүүл хийж, судалгааны талбай гарган, сургалт зохион байгуулж иржээ. Түүнчлэн, нөхөрлөлүүдэд ойн дагалдах баялгийг давуу эрхтэйгээр ашиглуулах, бэлчээрийг хариуцлагажуулах журмыг ОНТХГ-т мөрдүүлж, хэвшүүлэх ажлыг хийжээ. 2019.3.7-нд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд “Хариуцлагатай ойн менежмент” анхдугаар зөвлөгөөн зохион байгуулсан байна. Эдгээр нь COVID-19 халдвар тархаж, хөл хорио тогтоосон үеийг хамарсан хоёрхон жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажил учир үр дүн нь бүрэн илэрч гараагүй байх магадлалтай. Ойн тогтвортой менежментийг бий болгох нь илүү урт хугацаанд үр дүнд хүрэх ажил юм. Иймд энэ чиглэлээр иргэдийн хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлэх нь уг төслийн гол үр дүнгийн хэмжилт болж болох юм.

Мод бэлтгэл, жимс, самар түүх зэргээр байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах нь маш чухал ач холбогдолтой гэж судалгаанд оролцсон 150 өрхийн 89 өрх буюу 59.3%, ерөнхийдөө ач холбогдолтой гэж 30 өрх буюу 22.0% үнэлсэн байна. Эндээс үзэхэд иргэдийн 81.3% нь ойн тогтвортой менежментийн үндэс болсон дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол өгсөн байна. (Дүрс 43) Энэ үнэлгээнд нас, хүйс, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарч, ялгаатай хариулт өгсөн эсэхийг шинжлэхэд статистикийн ач холбогдолтой ялгаа байсангүй. Харин боловсролын түвшнээс хамаарч ялгаатай үнэлгээ өгсөн байна. Тодруулбал, дээд боловсролтой иргэдтэй харьцуулахад техник, мэргэжлийн болон түүнээс доош түвшний боловсролтой иргэд байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах нь дундаж ач холбогдолтой эсвэл ач холбогдолгүй гэж үнэлэх магадлал 42.3% ($s.e = 0.158$; $p - value 0.008$)-аар өндөр байна.

Дүрс 43. Байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах байдал, n=150



Дүрс 44. Хууль бус мод бэлтгэл, байгалийн нөөцийн зөвшөөрөлгүй ашиглалттай иргэн бүр тэмцэх шаардлагатай, n=150



Хууль бус мод бэлтгэл, байгалийн нөөцийн зөвшөөрөлгүй ашиглалттай иргэн бүр тэмцэх шаардлагатай гэдэгтэй нийт судалгаанд оролцсон 150 өрхийн хоёр өрх буюу 1.3% огт санал нийлэхгүй, 5 өрх буюу 3.3% ерөнхийдөө санал нийлэхгүй байсан бол үлдсэн 143 өрх буюу 95.3% санал нийлж байв. (Дүрс 44) Судалгаанд оролцогчийн нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс үл хамаарч энэ үр дүн гарсан байна.

Түүвэр судалгааны өгөгдөлд хийсэн статистикийн шинжилгээний үр дүнгээс дүгнэхэд байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах нь ач холбогдолтой гэж нийт өрхийн 81.3%, хууль бусаар мод бэлтгэж, нөөц ашиглаж байгаа байдлыг таслан зогсооход иргэн бүр оролцоо чухал гэдэгтэй нийт өрхийн 95.3% нь санал нийлж байна. Иймд нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгохын ач холбогдол, үр өгөөжийг иргэд нийтээр ойлгож, дэмжих хандлагатай байна. Харин дээд боловсролтой иргэдтэй харьцуулахад техник, мэргэжлийн болон түүнээс доош түвшний боловсролтой иргэд байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах байдалд харьцангуй сул ач холбогдол өгсөн байгааг анхаарах хэрэгтэй.

Бэлчээрийн тогтвортой менежмент бүхий орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг бий болгох талаар иргэдийн хандлага


Төсөл хэрэгжүүлэгчид Булган сумын бэлчээрийг зохистой ашиглах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх журам боловсруулан, хэрэгжүүлж, бэлчээрээ зохистой ашиглаж, тордон сайжруулсныхаа үр ашгийг малчид өөрсдөө хүртэх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажилласан байна. Нөхөрлөлүүдийн статусыг тодорхой болгож, бэлчээр ашиглалтын гэрээтэй, бэлчээр хамгаалах таван жилийн ажлын төлөвлөгөөтэй, 37 бэлчээрийн мониторингийн цэгтэй болж, ургамлаа таньж мэдэн, үйл ажиллагаа явуулах боломжтой болжээ. Эдгээр ажлын үр дүнд төслөөс үр шим хүртэгч өрхүүд бэлчээрийн тогтвортой менежмент бүхий орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг бий болгох асуудалд хэрхэн хандаж байгааг асуулгын аргаар үнэллээ.

Судалгаанд оролцсон нийт 150 өрхийн 136 өрх буюу 90.6% байгаль орчноо хайрлан хамгаалахын ач холбогдолыг өндөр гэж үнэлсэн бол ач холбогдолгүй гэж үнэлсэн өрх байхгүй байна (Дүрс 45). Энэ үнэлгээнд судалгаанд оролцогчийн нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой зөрүү байгаа эсэхийг шинжлэхэд нас болон хүйсээс хамаарсан ялгаа гараагүй. Харин боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарч ялгаатай үнэлгээ өгсөн нь статистикийн шинжилгээгээр тогтоогдлоо. Тодруулбал, дээд боловсролтой иргэдтэй харьцуулахад техник, мэргэжлийн болон түүнээс доош боловсролтой иргэд байгаль, орчныг хайрлан хамгаалахын ач холбогдлыг бууруулж үнэлэх магадлал 36.1% ($s.e = 0.06$; $p - value = 0.000$)-аар илүү байна.

Дүрс 45. Байгаль орчныг хайрлан, хамгаалахын ач холбогдол, n=150



Дүрс 46. Бэлчээр ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулахын ач холбогдол, n=150



Бэлчээр ашиглалтыг нөхөрлөл, холбооны үйл ажиллагаа, дүрэм, журмаар зохицуулах нь маш их ач холбогдолтой гэж нийт судалгаанд оролцогчдын 56.0%, ерөнхийдөө ач холбогдолтой гэж 22.7% нь үнэлжээ (Дүрс 46). Өөрөөр хэлбэл дөрвөн иргэн тутмын гурав нь бэлчээр ашиглалтыг зохицуулах дүрэм, журам, тогтвортой менежмент байх нь ач холбогдолтой гэж үзсэн байна. Энэ хариултад судалгаанд оролцогчийн нас, хүйс, боловсрол, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй.

Дээрх шинжилгээнээс **иргэдийн дийлэнх нь бэлчээрийн тогтвортой менежмент бүхий орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг бий болгохын ач холбогдлыг өндрөөр үнэлдэг болсон нь харагдаж байна.**

Орлогын олон талт эх үүсвэр бий болгох, малчид, нутгийн иргэд хамтран ажиллах талаар иргэдийн хандлага


Иргэд байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаж, олон төрлийн эх үүсвэрээс орлого олох боломжтой байх нь ядуурлыг бууруулж, амьжиргааг дээшлүүлэх үндэс суурь юм. Төслийн хүрээнд жендэрийн эрх, тэгш байдлыг хангаж, иргэдэд ажлын байр бий болгон, амьжиргаа, эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал ажлуудыг хийсэн байна. Тодруулбал, малчид, нутгийн иргэдийг нөхөрлөл хэлбэрт оруулж, эрхзүйн чадамжтай хуулийн этгээд болгон зохион байгуулсан байна. Ингэснээр тэд илүү бүтээмжтэй, илүү хариуцлагатай, мөн илүү эрх эдлэх боломжтой болжээ. Түүгээр зогсохгүй нөхөрлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтууд явуулж, нөхөрлөл бүр жижиг бизнес төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд төслөөс мөнгө, санхүү, техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байна. Малчид, нутгийн иргэд байгалийн нөөцийн зохистой ашиглалт болон ноос, ноолуур зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүнээ дундын дамжлагагүйгээр аж ахуй нэгж байгууллага, эцсийн хэрэглэгчдэд хүргэх боломжийг бүрдүүлж, холбогдох байгууллагуудтай гэрээ, хэлцэл хийсэн байна. Энэ бүхний үр дүнд нөхөрлөлийн гишүүд ойн цэвэрлэгээ хийж, түлээ түлш болгон худалдах, үзэсгэлэн худалдаанд оролцож, бүтээгдэхүүнээ борлуулах зэргээр олон талын эх үүсвэрээс орлого олох боломжтой болжээ. Мөн чухал нэг үр дүн бол тэд нөхөрлөлийн дундын сан байгуулж, амжилттай хэрэгжүүлж байна. Нөхөрлөлийн гишүүд дундын санд сар бүр хуримтлал үүсгэн, хамтын шийдвэрээр түүнийг үр ашигтай зарцуулж, үйл ажиллагаагаа санхүүжүүлэн нөхөрлөлийн гишүүдэд барьцаа хөрөнгөгүй, бага хүүтэй зээл олгодог болжээ.

Төслийн дээрх үйл ажиллагаануудын үр дүнд малчид хамтран ажиллаж, олон эх үүсвэрээс орлого олж, амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой эсэх талаар иргэд хэрхэн хандаж байгааг тандан судаллаа.


Дүрс 47-өөс харахад иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилготой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь ач холбогдолтой гэж дөрвөн хүн тутмын гурав (52.7% нь маш их ач холбогдолтой, 22.7% нь ерөнхийдөө ач холбогдолтой) нь үнэлсэн байна. Энэ үнэлгээнд судалгаанд оролцогчдын нас, хүйс, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой ялгаатай хариулт

гарсангүй. Харин дээд боловсролтой иргэдтэй харьцуулахад техник, мэргэжлийн болон түүнээс доош түвшний боловсролтой иргэд энэ төрлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийн ач холбогдлыг багаар үнэлэх магадлал 43.9% ($s.e = 0.236$; $p - value = 0.065$)-аар илүү байна.

Дүрс 47. Иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилготой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхын ач холбогдол, $n=150$




Дүрс 48. Орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулахын ач холбогдол, $n=150$



Нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулах нь маш их ач холбогдолтой гэж нийт судалгаанд оролцогчдын 54.0% үзсэн бол, ерөнхийдөө ач холбогдолтой, дундаж ач холбогдолтой гэж тэдний 21.3%, 20.7% тус тус үнэлсэн байгааг (Дүрс 48)-өөс харж болно. Харин нийт судалгаанд оролцсон 150 өрхийн зургаан өрх буюу 4.0% нь нөхөрлөл, хоршоо байгуулах нь ямар ч ач холбогдолгүй, эсвэл ач холбогдол багатай гэж үзжээ. Эдгээр үнэлгээнд судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшнээс хамаарсан ялгаа байгаа эсэхийг вариацийн шинжилгээгээр шинжлэхэд статистикийн ач холбогдолтой зөрүү гараагүй. Харин нөхөрлөлийн гишүүн болон гишүүн бус өрхүүд ялгаатай хариулт өгсөн нь 95%-ын итгэх завсарт нотлогдлоо. Тодруулбал, нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад нөхөрлөлийн гишүүн өрх орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжсэн нөхөрлөл, хоршоо байгуулах нь ач холбогдолтой гэж үнэлэх магадлал 65.0% ($s.e = 0.362$; $p - value = 0.075$)-аар илүү байв.

Иргэд нийгэм, эдийн засгийн харилцаанд орохдоо байгалийн нөөц, баялгаа зүй зохистой ашиглахын сацуу Монгол өв соёл, уламжлалаа хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх нь хариуцлагатай иргэн бүрийн үүрэг билээ. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 68.7% нь өв соёлоо хайрлан хамгаалах нь маш их ач холбогдолтой гэж үнэлсэн бол ерөнхийдөө ач холбогдолтой, дундаж ач холбогдолтой гэж 16.7%, 13.3% нь тус тус үнэлжээ. Харин 1.3% буюу хоёр иргэн ач холбогдол багатай гэж үзсэн байна. (Дүрс 49) Эдгээр хариултад нөхөрлөлийн гишүүн эсэх, нас, хүйсээс хамаарсан ялгаатай хариулт ажиглагдаагүй. Харин боловсролын түвшнээс хамаарсан ялгаатай хариулт байгаа нь статистикийн шинжилгээгээр тогтоогдлоо. Тодруулбал, дээд боловсролтой иргэдтэй харьцуулахад техник, мэргэжлийн болон түүнээс доош түвшний боловсролтой иргэд өв соёлоо хайрлан хамгийн ач холбогдлыг багаар үнэлэх магадлал 38.5% ($s.e = 0.125$; $p - value = 0.002$)-аар өндөр байв.

Дүрс 49. Өв соёлыг хайрлан хамгаалахын ач холбогдол, n=150



Дүрс 50. Иргэд боловсруулсан бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөл бүрдсэн эсэх, n=150



Төслийн гол үр дүнгийн нэг нь иргэд байгалийн болон соёлын нөөцөө зүй зохистой ашиглаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн, зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх явдал байв. Судалгаанд хамрагдсан өрхүүдээс эдгээр боломж, нөхцөл бүрдсэн гэдэгтэй хэр санал нийлж байгааг асуув. 150 өрхийн 76 өрх буюу 50.7% боловсруулсан бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөл бүрдсэн гэдэгтэй маш их санал нийлж байна гэсэн хариултыг өгчээ. 55 өрх буюу 36.7% нь энэ боломж, нөхцөл бүрдсэн гэдэгтэй ерөнхийдөө санал нийлж байгаа бол 16 өрх буюу 10.7% нь санал нийлэхгүй, гурван өрх буюу 2.0% нь огт санал нийлэхгүй байгаагаа илэрхийлжээ (Дүрс 50). Эдгээр хариултад судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой зөрүү ажиглагдсангүй.

Дээрх шинжилгээний үр дүнд байгалийн нөөц, баялгаа зохистой ашиглан, уламжлалт өв соёлоо хайрлан хамгаалж, малчид, нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нь ач холбогдолтой гэж ойролцоогоор дөрвөн хүн тутмын гурав нь үнэлжээ. Энэ үнэлгээ техник, мэргэжлийн болон түүнээс доош түвшний боловсролтой иргэд өв соёлоо хайрлаж, хамгаалахын ач холбогдол, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийн ач холбогдлыг бууруулж үнэлэх магадлалтай байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх олонх буюу 87.4% иргэд байгалийн болон соёлын нөөцөө зүй зохистой ашиглаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн, зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөл одоогоор бүрдсэн гэдэгтэй санал нийлж байгаа байдал нь малчид, нөхөрлөлийн гишүүд орлого олох олон талт эх үүсвэртэй болжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Түүнчлэн орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулах нь ач холбогдолтой юм гэж нийт өрхийн 75.3% үнэлсэн төдийгүй нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад гишүүн өрх энэ ач холбогдлыг илүү өндөр үнэлэх магадлалтай байгаа нь уг төслийн чухал үр дүн юм.

ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэхтэй холбоотой иргэдийн хандлага

Төслийн үндсэн зорилго ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалж, ОНТХГ-т хамгааллын жишиг менежментийг нэвтрүүлэх явдал байв. Энэ хүрээнд Булган сумын засаг даргын тамгын газар, нутгийн иргэд, малчидтай хамтран ажилласан байна. Түүнчлэн Архангай аймгийн удирдагууд, аймгийн байгаль орчны газар, ойн анги, экологийн цагдаа нартай нягт хамтран ажиллажээ. Үүний үр дүнд нутгийн иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, 2019.3.26-нд нөхөрлөл бүрийн төлөөлөл оролцсон нөхөрлөлүүдийн холбоог албан ёсоор байгуулан, дүрэм, журмыг боловсруулж, эрх зүйн чадамжтай хуулийн этгээд болгожээ. Ингэснээр нөхөрлөлийн гишүүд эвлэлдэн нэгдэж, дуу хоолойгоо нутгийн удирдагуудад хүргэх боломж бүрдсэнээс гадна хамтран ажиллаж, ур чадвараа ахиулах, сургалтад хамрагдах, идэвхтэн байгаль

хамгаалагчидтай болж, байнгын судалгааны талбай дээрээ ойн болон бэлчээрийн судалгаагаа хийж, байгаль орчноо тордон сэргээх, зохистой ашиглах, хайрлан хамгаалахад олон талын оролцоотойгоор хамтран ажиллах боломжтой болсон байна. Хойд могойн гол орчмын 137,018 га газрыг Тээлийн ОНТХГ-т авсан нь уг төслийн чухал үр дүнгүүдийн нэг юм.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежментийг нэвтрүүлэхийн үр өгөөж, ач холбогдлыг иргэд хэрхэн үнэлж, энэ талаар ямар үзэл бодол, хандлагатай байгааг түүвэр судалгаагаар тандан судаллаа.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгаль хамгаалах менежментээр дамжуулан ан амьтдыг хамгаалах зайлшгүй шаардлага тулгараад байна гэдэгтэй судалгаанд оролцсон 150 өрхийн дийлэнх нь санал нийлж байв. Нэг өрх (0.7%) л санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн нь Дүрс 51-аас харагдана. Энд иргэдийн нас, хүйс, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан ялгаатай хариулт гараагүй. Харин боловсролын түвшнээс хамаарсан ялгаатай хариулт ажиглагджээ. Өөрөөр хэлбэл, дээд боловсролтой иргэдтэй харьцуулахад техник, мэргэжлийн болон түүнээс доош түвшний боловсролтой иргэд энэ төрлийн менежментээр дамжуулж, ан амьтдыг хамгаалах зайлшгүй шаардлага тулгараад байгааг маш их санал нийлэх байдал 20.1% ($s.e = 0.113$; $p - value = 0.080$)-аар бага байх магадлалтай байна.

Дүрс 51. Ан амьтдыг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарсан эсэх, n=150



Дүрс 52. Тусгай хамгаалалттай газар, бүс бий болгохын ач холбогдол, n=150



Дүрс 52-дэх үзүүлэлтүүдийг тоймлон тооцоход судалгаанд хамрагдсан гурван хүн тутмын нэг нь тусгай хамгаалалттай газар, бүс бий болгох нь дундаж ач холбогдолтой, эсвэл ач холбогдол багатай гэж үзсэн бол гурван хүн тутмын хоёр нь ерөнхийдөө ач холбогдолтой, эсвэл маш их ач холбогдолтой гэж үнэлжээ. Энд нөхөрлөлийн гишүүн эсэх болон хүйсээс хамаарсан ялгаатай хариулт ажиглагдаагүй. Харин 39-өөс доош насны 69 иргэний 60.1% нь ач холбогдол өгсөн байхад 40-өөс дээш насны 81 иргэний 65.1% нь ач холбогдол өгсөн байна. Түүнчлэн, дээд боловсролтой иргэдийн 66.7% ач холбогдолтой гэсэн бол техник, мэргэжлийн болон түүнээс доош боловсролтой иргэдийн 63.1% ач холбогдолтой гэж үнэлжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан "Байгаль хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн" гэсэнтэй судалгаанд оролцогчид хэр санал нийлж байгааг асуун, байгаль хамгаалал дахь иргэдийн оролцооны талаарх үзэл бодол, хандлагыг тодорхойлохыг хичээв. Судалгаанд хамрагдсан иргэд бараг бүгд энэ үүргээ ухамсарласан байгаа нь Дүрс 53-аас харагдаж байна. Иргэдийн нас ахихын хэрээр энэ өгүүлэмжтэй санал нийлэх байдал нэмэгдэж байсан бол боловсролын түвшин буурахын хэрээр байгаль хамгаалах нь иргэн бүрийн журам үүрэг мөн гэдэгтэй санал нийлэх байдал буурах магадлалтай (үнэлэгдсэн коэффициент = 24.8%; $s.e = 0.041$; $p - value = 0.000$) байна.

Дүрс 53. Байгаль хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн эсэх, n=150



Дүрс 54. Байгаль хамгаалахад иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай эсэх, n=150



Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээгээр дамжуулж, ойт хээрийн экосистемийг хамгаалахад иргэд (ойн нөхөрлөл, бэлчээр ашиглалтын хэсгүүд), орон нутгийн засаг захиргааны байгууллага (байгаль орчны газар, ойн анги, газрын алба, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллага)-ууд хамтран ажиллах шаардлагатай гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 98.0% нь үзсэн байгааг Дүрс 54-д үзүүлэв. Энэ байдалтай огт санал нийлэхгүй гэж нэг өрх, ерөнхийдөө санал нийлэхгүй гэж хоёр өрх үнэлсэн ба эдгээр хариултад иргэдийн нас, хүйс, боловсролын түвшин, нөхөрлөлийн гишүүн эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой зөрүү ажиглагдсангүй.

Дээрх шинжилгээнээс дүгнэхэд ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд өндөр ач холбогдолтой гэж судалгаанд хамрагдсан бараг бүх иргэд үзжээ.

ДҮГНЭЛТ

Архангай аймгийн Булган сумын ОНТХГ-т бүртгэгдсэн газар нь 137,018 га газар ба Хангайн нурууны хэсэг болон 2 гол (Хойд Могойн гол, Тээл) орчимд ЛАСН-ийн хэрэгжүүлсэн “Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслийн хэрэгжилтийг “маш сайн” хэмээн оролцогч талууд болон нутгийн иргэдийн зүгээс хэмээн үнэлж байна.

Тээлийн ОНТХГ-ын иргэдийн нийгэм, эдийн засгийн байдалд хийсэн үнэлгээний дүгнэлт

ЛАСН-ийн хэрэгжүүлж буй “Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслийн үр дүнд Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол – Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал хэрхэн өөрчлөгдсөнийг ядуурлын олон хэмжээст индексээр болон бусад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр үнэлж, суурь 2018 онтой харьцуулж, дүгнэлээ.

ОХЯИ нь боловсрол, эрүүл мэнд, амьдралын нөхцөл гэсэн үндсэн гурван бүлэг үзүүлэлтээр эмзэг, өртөмтгий болсон өрхийн эзлэх хувийг нэгтгэн харуулдаг. Суурь 2018 онд судалгаанд оролцсон 150 өрхийн 29.7% нь эдгээр үзүүлэлтүүдээр эмзэг, өртөмтгий байсан бол төслийн төгсгөлийн үнэлгээг хийх үед судалгаанд хамрагдсан мөн 150 өрхийн 22.9% нь эмзэг, өртөмтгий байдалтай байна. Суурь онд ядууралд өртсөн өрхүүдийн 38.9% нь нийт үзүүлэлтийн хувьд гачигдалтай байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 36.5% болж буурчээ. Иймд ОХЯИ-ийн үнэлгээгээр сүүлийн гурван жилийн хугацаанд Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын нөхцөл ерөнхийдөө сайжирсан байна. Тодруулбал, уг индексийн бүрэлдэхүүн 10 үзүүлэлтээс 7 үзүүлэлт сайжирсан, өрхийн гишүүдийн суралцсан жил, нялхасын эндэгдэл, гэр байр, орон сууцны шал гэсэн гурван үзүүлэлт муудсан байв.

Суурь онд өрх сард дунджаар 553'837 төгрөгний орлого олж байсан бол 2020 онд 963'245 төгрөгийн дундаж орлоготой болж, орлого олдог хүний тоо, орлого олох эх үүсвэрийн тоо нэмэгдсэн байна. Мөн орлогын хүрэлцээ харьцангуй сайжирч, сүүлийн гурван жилийн хугацаанд амьжиргаа дээшилсэн гэж 150 өрхийн 40.7% үнэлсэн ба бүх өрх өөрийн амьдралдаа сэтгэл хангалуун байна.

Суурь судалгаагаар орон нутгийн иргэд амьжиргаагаа дээшлүүлэхэд бизнес эрхлэх туршлага хомс, санхүүгийн мэдлэг, техникийн ур чадвар сул гэсэн дүгнэлт гарч байсан бол эцсийн шатны үнэлгээгээр нийт өрхийн 94.7% нь нөхөрлөлийн гишүүн болж, бизнес төлөвлөгөө, төсөл бичин, тоног төхөөрөмж болон бусад төрлийн дэмжлэгийг төслөөс авч, хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулан, хэрэгцээгээ хангахаас гадна зах зээлд нийлүүлж, амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой болжээ. Түүнчлэн нөхөрлөлийн дундын хуримтлалын бүлэгт 150 өрхөөс 140 өрх нэгдэж, ноогдол ашиг авах болсноор өрхийн орлогоо нэмэгдүүлэхээс гадна санхүүгийн боловсрол эзэмшиж, нутгийн иргэд хамтран ажиллах арга дадалд суралцжээ. Үүнээс гадна нөхөрлөлийн гишүүд нэгдсэн журмаар бэлчээрээ зүй зохистой ашиглах, ой, мод, гол усаа цэвэрлэх зэргээр байгаль орчноо хамтын хүчээр хайрлан хамгаалж, нөөцийг зүй зохистой ашигладаг болсон байна. Иймд төслийн үр дүнд бий болсон байгалийн нөөцийн хамтын менежмент бүхий нөхөрлөл нь гишүүн өрхийн амьжиргаанд төдийгүй байгаль орчинд өндөр ач холбогдолтой, үр өгөөжтэй болсон нь харагдаж байна.

Төслийн үр нөлөө, хэрэгжилтийн үнэлгээ хэсгийн дүгнэлт

Орон нутгийн иргэд үзэж буйгаар сүүлийн 3 жилийн хугацаанд **зэрлэг амьтны тоо толгой** 44%-иар өссөн, хулгайн ан агнуур 59.3%-иар багассан хэмээн үзэж байна. Төслийн зорилтот амьтдаас буга, тарваганы тоо, толгой мэдэгдэхүйц өссөн байна. Ховордож байгаа амьтдын тоо толгой өсөж байгааг нутгийн иргэдийн хувьд тарваганы дош олширсон, буганы унасан эвэр харагдах болон сүрэглэн

бэлчээрлэх тохиолдол нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж байна. Байгалийн ховордсон амьтдын тоо толгой өсөж байгаа нь төслийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болох камержуулалт, нөхөрлөлийн гишүүдийн эргүүл хяналт, хулгайн мод бэлтгэлийн зөвшөөрөлгүй зам давааг хаасан болон хууль дүрмийн хэрэгжилт сайжирсан, иргэдийн мэдлэг хандлага өөрчлөгдсөнтэй холбон тайлбарлаж байна. Үүнээс дүгнэж үзвэл төслийн үндсэн зорилт болох ховордож буй амьтадын хамгаалал ба мониторингийн тогтолцоо бий болгох зорилт хэрэгжсэн байна.

Төсөл хэрэгжсэнээр **ойн нөхцөл байдал** сайжирсан гэсэн хариулт 14.7 функтээр өссөн, муудсан гэсэн 22.7 функтээр буурсан нь гурван жилийн хугацаанд гарсан маш сайн үзүүлэлт юм. Мөн хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлэл авсан өрх 18 функтээр нэмэгдсэн байгаа нь иргэдийн хяналтын эрүүл тогтолцоо сайжирсантай холбон ойлгож болно. Төсөл хэрэгжихээс өмнө ой бүхэлдээ хямралд өртсөн байсан хэмээн судалгаанд оролцогчид тодорхойлсон. Учир энэхүү ОНТХГ-аас нутгийн иргэд зөвшөөрөлгүй түлшний мод бэлтгэж байсантай холбоотой. Харин төсөл хэрэгжсэний дараа нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулж эхэлснээр зөвшөөрөлгүй замуудыг хаах, камержуулах, идэвхтэн байгаль хамгаалагчийн хяналттай холбоотой нөхцөл байдал маш дээрдсэн байна. Мөн нөхөрлөлд ойн цэвэрлэгээний зөвшөөрөл бүхий талбайг зааж өгсөнөөр нутгийн иргэдийн мод бэлтгэлийг хянах боломжийг олгохын зэрэгцээ иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна. Мөн хулгайн мод бэлтгэл багассан байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд бэлчээрийн нөхцөл байдалд өөрчлөлт гараагүй байна. Өөрөөр хэлбэл төслийн зүгээс бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлд хийсэн ажлуудын үр дүн гараагүй байна. Бэлчээрийн нөхцөл муудаж байгаа шалтгааныг малчид тайлбарлахдаа голлон малын тооны өсөлт болон байгаль цаг уурын өөрчлөлттэй холбон тайлбарлаж байна. **Байгаль цаг уурын өөрчлөлтийг төслөөс болон малчдын зүгээс удирдах боломж хязгаарлагдмал байна.** Орон нутгийн иргэдийн хувьд бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор бэлчээр сэлгэн нүүдлэх, хадлангийн талбай хашаалах, өвөлжөө газраа намар, хавартаа нутаглах байх зэрэг алхамуудыг хэрэгжүүлж байгаа ч үр нөлөө бага үзүүлсэн байна.

Нутгийн иргэдийн үзэж буйгаар нөхөрлөлд хамрагдсан өрхүүдийн **орлогын олон талт байдал нэмэгдсэн** байна. Орлого нэмэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь ойн цэвэрлэгээний орлоготой холбоотой байна. Төслийн зүгээс өрхийн орлогын олон талт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ойн цэвэрлэгээ хийх тоног төхөөрөмж болон нөхөрлөлийн дундын санг бий болгох, аж ахуй эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн үр дүнтэй болсон байна. Орон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр нь уламжлалт мал аж ахуй болох мах, ноос ноолуураас бүрэн хамааралтай байсан бол төслийн үр дүнд орлогын олон талт байдал нэмэгдэж ойн цэвэрлэгээнээс түлшний мод бэлтгэх, сүү цагаан идээ, аялал жуулчлалаас орлого олох боломж нэмэгдсэн байна.

Оролцогч талуудын үзэж буйгаар ОНТХГ-ын **хамтын менежментийг** бий болгох үйл ажиллагаа “маш сайн” үр дүнтэй байгааг онцолж байна. ОНТХГ-т хамтын менежментийг бий болгосноор суурь түвшнээс илүү эерэг өөрчлөлтүүд гарч байна. Төсөл орон нутгийн иргэд сайн хамтын ажиллагааг бий болгож чадсан хэмээн үзэж байна. ОНТХГ-т 11 нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна. Нөхөрлөлийн гишүүдийн хувьд одоогийн явуулж байгаа нөхөрлөлийн үйл ажиллагааг “маш сайн” хэмээн үнэлж байна. Төслийн үр шим хүртэгчдийн хувьд төслийн үйл ажиллагаа болон төслөөс олгосон дэмжлэгүүд шаардлагатай, үр ашигтай байдлыг “маш сайн” хэмээн үнэлж байна. ОНТХГ-ын менежментийн ойт хээрийн экосистемийг хамгаалахад иргэд орон нутгийн засаг захиргааны байгууллага хамтран ажиллах шаардлагатайг талууд онцолж байна.

Иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагын үнэлгээний дүгнэлт

Иргэдийн оролцоотой байгаль хамгааллын жишиг менежментийг нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа харьцангуй урт хугацаанд үр дүнгээ өгөх ажил юм. Тиймээс байгаль хамгаалах, байгалийн нөөцөө зүй зохистой ашиглахад орон нутгийн оршин суугчдын хүчин зүтгэл чухал ач холбогдолтой юм гэдгийг иргэд ойлгосон байх нь уг төслийн богино хугацааны нэг чухал үр дүн болно.

Судалгааны үр дүнд байгалийн нөөц ашиглалтыг дүрэм, журмаар зохицуулах, ховордож буй амьтны хамгаалал, мониторинг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж иргэд үзэж байв. Түүнчлэн хууль бусаар мод бэлтгэж, нөөц ашиглаж байгаа байдлыг таслан зогсооход иргэн бүр оролцоо чухал гэдэгтэй нийт өрхийн 95.3% нь санал нийлж байна. Иймд нутгийн иргэдэд түшиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгохын ач холбогдол, үр өгөөжийг иргэд нийтээр ойлгож, дэмжих хандлагатай байна. Мөн бэлчээрийн тогтвортой менежмент бүхий орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг бий болгохын ач холбогдлыг тэд өндрөөр үнэлжээ.

Байгалийн нөөц, баялгаа зохистой ашиглан, уламжлалт өв соёлоо хайрлан хамгаалж, малчид, нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нь ач холбогдолтой гэж ойролцоогоор дөрвөн хүн тутмын гурав нь үнэлсэн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн олонх нь байгалийн болон соёлын нөөцөө зүй зохистой ашиглаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн, зах зээлд нэвтрүүлэх боломж, нөхцөл одоогоор бүрдсэн гэдэгтэй санал нийлж байгаа байдал нь малчид, нөхөрлөлийн гишүүд орлого олох олон талт эх үүсвэртэй болжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Түүнчлэн орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулах нь ач холбогдолтой гэж нийт өрхийн 75.3% үнэлсэн төдийгүй нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад гишүүн өрх энэ ач холбогдлыг илүү өндөр үнэлэх магадлалтай байгаа нь уг төслийн чухал үр дүн юм.

Дээрх байдлаас үзэхэд байгаль хамгаалалд иргэн бүр оролцож, ОНТХГ-т үр дүнтэй хамгааллын менежмент нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд өндөр ач холбогдолтой гэж төслөөс үр шим хүртэгчид үзжээ.

ЗӨВЛӨМЖ

- ЛАСН-аас гурван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн энэхүү төслийн хүрээнд Тээлийн голын ОНТХГ-т оршин суугаа иргэд олон эх үүсвэрээс орлого олох боломжтой болж, хөдөө аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулан хэрэгцээгээ хангахаас гадна зах зээлд нийлүүлэх замаар амьжиргаагаа дээшлүүлж, сэтгэл хангалуун амьдарч байна. Төсөл эхлэх 2018 онд бизнес эрхлэх туршлага хомс, санхүүгийн мэдлэг, техникийн ур чадвар сул байсан иргэдийг энэ гурван жилийн хугацаад чадавхжуулан сургаж, хамтран ажиллах боломжоор хангаснаар тэдний амьдрах чадвар сайжирчээ. Бэлэнчлэх бус чадваржуулах бодлого хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй юм гэдгийг энэхүү төслийн үр дүн харууллаа. Иймд иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдэж байсан төслийн бүхий л үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах нь чухал ач холбогдолтой байна. Энд Булган сумын засаг, захиргааны байгууллага онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
- Төсөл хэрэгжсэн гурван жилийн хугацаанд иргэд ОНТХГ-т иргэдийн оролцоотой хамгааллын менежмент нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой юм гэсэн үзэл бодол, хандлагатай болжээ. Зөв үзэл бодол, хандлага тогтсон энэ үед иргэдийн оролцоонд тулгуурласан байгаль хамгааллын менежментийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх нь чухал байна.
- Төслийн үнэлгээний үр дүнд иргэдийн боловсролыг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдлаа. Тодруулбал, ОХЯИ-ээр боловсролын нэг үзүүлэлтээр гачигдалтай, эмзэг байдалтай гэж үнэлэгдсэн бол боловсрол өндөр иргэдтэй харьцуулахад боловсрол доогуур иргэд нутгийн иргэдийн оролцоотой байгаль хамгаалах үйл ажиллагааны ач холбогдлыг багаар үнэлэх хандлагатай байв. Түүнчлэн төслийн үйл ажиллагаа иргэдийг сургах, чадавхжуулахад түлхүү чиглэсний үр дүнд богино хугацаанд нийгэм, эдийн засгийн байдалд харьцангуй өндөр ахиц гаргаж чадсан. Цаашдаа иргэдийн боловсролыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллавал аливаа үйл ажиллагааны үр дүн ахиц, дэвшил сайн байх төлөвтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. *Aichi Biodiversity Targets*. (2020). Convention on Biological Diversity: <https://www.cbd.int/aichi-targets/target/19-ээс> Гаргасан
2. Alkire Sabina, et al. (2011). Multidimensional Poverty Index 2011: Brief Methodological Note. *Oxford Poverty & Human Development Initiative (OPHI)*, 1-14.
3. Brigs, S., & Narantungalag, O. (2017). *Assessment of Development Programmes' Implementation Compliance with M&E Resolution 322/89 – using as Pilot a MFALI Development Programme*. EU funded EG4EG Project.
4. Monica Wrobel, Tungalag Ulambayar, Samuel Merson, Erdenetsolmon Ganbaatar, Khaliun Tsog. (2020). *Darwin Initiative Main and Post Project Annual Report*. Ulaanbaatar: Zoological Society of London.
5. UNDP. (2017). *Development Finance Assessment for Mongolia: Diversifying finance for sustainable development*.
6. United Nations, Sustainable Development Goals. (2015-2030). *Sustainable Development*. Department of Economic and Social Affairs: <https://sdgs.un.org/goals-ээс> Гаргасан
7. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2020). Өрхийн тоо, сум/дүүргээр. Булган сум, Архангай аймаг, Хангайн бүс.
8. Хараат бус судалгааны хүрээлэн. (2018.9-2019.2). *Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт оршин суугаа иргэдийн нийгэм-эдийн засгийн суурь судалгаа*. Улаанбаатар: Лондоны Амьтан Судлалын нийгэмлэг
9. Darwin Initiative Main and Post Project Annual Report, Улаанбаатар: Лондоны Амьтан Судлалын нийгэмлэг